

ARD ӨАМХУУТИЙН
НЭГДЭЛ

2021

ЖИЛИЙН ТАЙЛАН

Агуулга

Гүйцэтгэх удирдлагын илгээлт	3	Хөрөнгө Оруулалт	74
Компанийн тухай	11	Крипто төслүүд	81
2021 оны онцлох үйл явдал	15	Эрсдэлийн удирдлага	84
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	22	Хууль, хянан нийцүүлэлт	86
Төлөөлөн Удирдах Зөвлөл	24	Хөрөнгө оруулалтын багц	88
Удирдлагын баг	35	Ард Даатгал (MSE: AIC)	92
Үйл ажиллагааны орчин	39	Ард Кредит (MSE: ADB)	96
Макро эдийн засаг	40	Ардын Тэтгэврийн Данс	100
Мөнгө, санхүү	44	Ард Актив	102
Хөрөнгийн зах зээл	45	Ард Менежмент	104
Түүхий эдийн зах зээл	48	Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)	107
Валютын зах зээл	50	Крипто Үндэстэн (MSE: BUN)	108
Криптовалютын зах зээл	51	Ард Секюритиз	109
Гол үзүүлэлт	53	АрдШоп	112
Үнэлгээ	56	Ард Лизинг	114
Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа	57	АрдЭкс (DAX)	116
Гүйцэтгэлийн тайлан	59	ТэнГэрЛиг Медиа Нэгдэл (MSE: TNGR)	119
Технологи	60	Монгол Шуудан (MSE: MNP)	122
Маркетинг	63	Бидний ойрын ирээдүй	124
Нийгмийн хариуцлага	70	Хараат бус аудитын тайлан	126
Хүний Нөөц	73		



Гүйцэтгэх удирдлагын илгээлт

Эрхэм хүндэт Ардын хувьцаа эзэмшигч танаа!

Өнгөрч буй 2021 он миний хувьд мэргэжлийн амьдралдаа үзэж, даван туулсан туйлын их савалгаатай, үлэмжийн өндөр өсөлтийг компанийн бүх хэмжээсээр гаргаж чадсан, хамгийн өндөр ачаалалтай, сэтгэл догдлуулсан, амжилт бүтээл, алдаа ухаарал дүүрэн жил болж өндөрлөлөө. Эргээд харахад үнэхээр их өөрчлөлтийг бид компани дотроо бий болгосноос гадна хүн ардын хувьд хувьсгалын гэмээр өөрчлөлтийг бид хийж чадсан. Энэ бүхэнд хамтдаа байсан та нартаа юуны түрүүнд талархал илэрхийлэхийг зөвшөөрнө үү.

Ковид-19 цар тахлын хөл хорио, төр засгаас авч хэрэгжүүлсэн бусад онцгой арга хэмжээ, олон улсын хил хязгаарлалтаас үүссэн аялал жуулчлал, худалдаа наймааны тасалдал, түүнээс улбаалсан нийгэм эдийн засгийн гүн цочрол дунд өрнөсөн 2021 оны Ардын гүйцэтгэлтэй холбоотой гол тавилтууд нь хавьгүй өмнө өрөгдөж эхэлсэн гэдгийг юуны өмнө хэлэх нь зүйтэй байх. Бид 2013 оноос хойш төлөвлөж, Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооё, хөрөнгийн зах зээл, банкны салбарын түүчээлэлийг явуулъя, КriptoҮндэстэн болж, IV аж үйлдвэрийн хувьсгалд оролцъё, салбаргүй, дижитал банк больё, Ард Апп, АрдКойн хоёр Хүчтэй бөгөөд Хамтдаа гэх алсын харааг баримталж, зорилго тавьж өрнүүлсэн ажлын үр дүн нь түрүү жил гарсан гэж харж болох боловч огт төсөөлөөгүй байдлаар бидний ажлыг асар их хурцалж, бас хурдасгасан, гүн гүнзгий бөгөөд өргөн нөлөөллийг тэс хөндлөнгөөс бүрдүүлсэн хүчин зүйлс олон гарч ирсэн. Эдийн засгийг сэргээхийн тулд төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, Ковид-19 цар тахлын хөл хорио зэрэг хүчин зүйлс дэлхий нийтээрээ крипто, NFT, DeFi, блокчэйнээр амьсгалах нөхцлийг бүрдүүлж, улмаар биткойны ханш өссөөр хамгийн дээд түвшиндөө хүрэв. Харин Монголчууддаа, бид Монгол ТВ – тэй хамтран Аппрентис Шоуг хүргэх мөчид Digital Assets Exchange буюу DAX-ыг зах зээлд амжилттай нэвтрүүлж, өмнөх 5 жилийн хөдөлмөр болох АрдКойн,

Ард Аппыг хэрэглэгчдэд амжилттай танилцуулсан явдлууд нь АрдКойн болон Ардтай холбоотой хувьцааны өсөлтөд тодорхой хэмжээнд нөлөөлснийг бид юун түрүүнд хүлээн зөвшөөрөх ёстой. Гэхдээ бидний Монголчууд чаддаг байсан, чадах болно гэдэг итгэл үнэмшлээрээ, хэлж, уриалсан, түүнийхээ дагуу хийж бүтээсэн бүх бэлтгэл ажил маань босгосон суурин дээрээ үр дүнгээ өглөө.

Монголын хөрөнгийн захын гол үзүүлэлт болж ирсэн ТОП-20 индексийн хувьд 130 хувиар өсөж, Блүүмберг **Монголыг дэлхийн номер нэг зах зээлээр өргөмжилсөн сайхан мэдээтэй хуучин оноо үдлээ.**

Тиймээс бид бие, биедээ баяр хүргэх ёстой болов уу. Учир нь энэхүү үзүүлэлтийг бүрдүүлсэн гол хүчин зүйл нь та бидний хамтын ажиллагаа байсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Ардын гэх тодотголтой бүх хувьцаа 2021 онд Монголын Хөрөнгийн Биржийн хамгийн өндөр өсөлттэй байснаас гадна нийт хувьцааны арилжааны дийлэнх хувийг эзэлсэн байдаг. Ингэснээрээ хөрөнгийн зах зээл рүү иргэдийг өргөнөөр татаж, үлэмж их хэмжээний мөнгөний урсгалыг бий болгосноос гадна бусад компанийн хувьцааны үнэ ханшид эерэг өөрчлөлт гаргах үндэс суурийг нь бид хамтдаа тавьсан болно.

Бид 2017 онд Кripto Үндэстэн болох уриалгыг та бүхэндээ хүргүүлж байсан бол Монгол Улс 2020 онд ФАТФ-ын саарал жагсаалтаас гарч,

2021 онд мөн л тэдний зөвлөмжийн дагуу өөрсдийн гэсэн Виртуал **Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгчийн тухай хуультай болж чадлаа.**

АрдКойноор эхэлсэн крипто шуурга Монголыг нэгмөсөн нөмөрч, бид блокчэйн технологи, криптовалютын тухай мэдлэг, хуримтлуулсан туршлага, хүн амын дундах нэвтрэлтээрээ дэлхийд тэргүүлж эхэллээ. Мэдээжийн хэрэг алдах зүйлс ч байсан. Цаашид ч энэ их койн, биржүүд хумигдах нь жам ёсны үйл явц. Зарим иргэд ч санхүүгийн хувьд хохирохыг үгүйсгэхгүй. Гэхдээ том зургаар нь харвал бид блокчэйн, криптогийн хувьсгалыг Монголдоо хийж чадсан гэж бодож байна. Энэ нь улс орны ирээдүйд эерэг нөлөө үзүүлэх зүйл гэж харж байна. Учир нь IV аж үйлдвэрийн хувьсгалд Монголчууд бид бүрэн дүүрэн оролцож, мөр зэрэгцэн алхаж чадлаа. Үүнийг АрдКойн манлайлж ирсэн бөгөөд цаашид өөрийн экосистемээ улам бүр төгөлдөржүүлэх онцгой байр суурин дээр очиж чадсан хэмээн дүгнэж байна. Кripto өвөл айсуу гэж хүмүүс ярьж байгаа нь оргүй зүйл биш бөгөөд АрдКойны үнийн хувьд зах зээл дээр коррекшн хийгдэж цаашдын зам дардан боллоо гэж би олзуурхаж байгаа. Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох

эрхэм зорилгынхоо хүрээнд бид экосистемээ улам бүр төгөлдөржүүлэх чиглэлд хэд, хэдэн томоохон алхмуудыг хийлээ. Нэн тэргүүнд, 2015 онд үүсгэн байгуулагдаад үйл ажиллагаа нь жигдэрч чадаагүй байсан Монголын Үнэт Цаасны Биржид шинээр хөрөнгө оруулж, Улаанбаатарын Үнэт Цаасны Бирж буюу UBX гэх шинэ брэнд, нэрийн дор ажлыг нь эхлүүлж чадсан юм. 2022 онд бид энэхүү биржид бусад мэргэжлийн тоглогчдыг хөрөнгө оруулагчаар оруулж ирэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх чиглэлд ихээхэн ахиц дэвшил гаргахаар ажиллаж байна.

Олон жил хэлж, ярьсан Чоно эдийн засаг-ийн суурийг бид цутгасаар буй гэдгийг та бүхэн харж байгаа биз ээ. **Бид Зорилготой, Зоригтой, Зогсолтгүй зүтгүүлсээр байгаа.**

Ард олон жилийн турш хамтран ажиллаж ирсэн ГрэйпСити Монгол, Мост Финтек хоёрт стратегийн хөрөнгө оруулалт хийж, тэдгээр компанийг цаашид олон нийтийнх болгох төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэллээ. Эдгээр компаниуд нь бидний өнөөг хүртэл барьж ирсэн буюу технологи дээр суурилсан санхүүгийн салбарын түйвээлтийг хийх, цаашид олон улсад тэлэх зорилгын хүрээнд хамтарч байгаа юм. Бид банк, санхүүгийн салбарын бүх тоглогчдод Ардтай мөр зэрэгцэж эдгээр компаниудад хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллахыг уриалж эхэлсэн. Та

ч гэсэн энэ талаар сонирхвол бидэнтэй холбогдохыг урья.

TNGR гэдэг тикерын дор Монголын анхны олон нийтийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн компани болох ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн нь бидний ажлын томоохон нэг үр дүн гэж харж байгаа.

Бид хамтарч, нэгдэж чаддаг
Бид хямралыг боломж болгож чаддаг
Бид хэлсэн ярьсандаа байж чаддаг

гэдгийг харуулсан энэ үйл явдлын цаана Монголын хамгийн том хэвлэл мэдээллийн компаниуд нэг баг болж, хэвлэл мэдээллийн салбарт бүтээлч түйвээлтийг өрнүүлэхээс гадна олон түмнийг соён гэгээрүүлэх, хараат бус, захиалгагүй сэтгүүл зүйг нутагшуулах, маш том ахиц дэвшил рүү тэмүүлэх ажилд шамдаж эхэллээ. Ард иргэд өөрсдөө хэвлэлийнхээ эзэн болох, шинэ дэвшилтэт технологийг энэ салбарт нэвтрүүлэх, санхүүгийн хувьд тулхтай, тунгалаг ажиллах боломжийг бид нээж өглөө.

Анх Е-Моние гэдэг хувьцаат компанитай хийсэн урвуу нэгдлийн үр дүнд бидний авсан нэгж хувьцааны үнэ оны эхэнд байсан 1,954 төгрөгөөс 20,000 төгрөг болж өсөв.

Ард түүний 41 орчим хувийг эзэмшиж байгаа бөгөөд цаашид энэ хувиа багасгаж ажиллах төлөвлөгөөтэй байна.

Криптовалютын багцад хөрөнгө оруулалт хийх зорилготойгоор 2017 онд байгуулагдсан, Монголдоо анхдагч Кripto Үндэстэн компани нь Монголын Хөрөнгийн Бирж дээр BUN тикер дор арилжаалагддаг Булган Ундрага ХК - тай нэгдсэнээр хувьцааны үнэ (BUN) оны эхний ханш болох 760 төгрөгөөс 200 мянган төгрөг хүртэл өссөн. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх хамгийн өндөр өсөлт байлаа. BUN-ы нийт үнэлгээ 18 тэрбум төгрөг болсон ба Ард түүний 67 хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг бөгөөд бид энэхүү компанийн засаглал, удирдлагыг сайжруулах, олон түмэнд хандсан маркетингийн ажлыг 2022 оноос илүү идэвхжүүлэх болно. Уг компанийн хувьцаагаар дамжуулж хувь иргэд, аж ахуйн нэгжүүд криптовалютын шууд савлагаанаас хамгаалагдаж, тогтвортой хөрөнгө оруулалт хийх үүдийг бид Монголдоо анхлан нээсэн нь энэ.

2021 онд Монголын санхүүгийн салбар болоод Ард Санхүүгийн Нэгдлийн гүйцэтгэлд хамгийн том нөлөө үзүүлсэн гол тоглогч бол мэдээжийн хэрэг DAX байсан. Оргил үедээ нийт хагас сая хүн анх удаагаа крипто арилжаанд оролцож,

АрдКойны үнэ ханшийг хагас жилийн дотор 450 дахин өсгөж чадсан нь Монголд крипто шуургыг эхлүүлэн 2 ихнайд төгрөгийн арилжаа явагдах боломжтой гэдгийг харуулж, араасаа 20-30 бирж гарах, 50-70 койн мэндлэх боломж нөхцлийг бүрдүүлсэн нь энэхүү биржийн гавьяа гэдэгтэй маргах хүн үгүй байх. Криптовалютын арилжаанд шууд оролцох боломжийг Ард Аппын хэрэглэгчдэд бий болгосноор бидний энэ амжилт анх тодорхойлогдсон бол технологийн асуудлаас болоод өөр шийдэл эрж хайхаас аргагүй болсон юм. Цаашид DAX-ын хувьд эргээд Ард Апптайгаа нягт уялдах, олон улсын түвшинд гарах ажлууд хүлээгдэж байна. Энэ чиглэлд бид хөрөнгө оруулалт хийж, iDAX биржийн үйл ажиллагааг оны эцсээр эхлүүлсэн юм. Цаашид АрдКойноор шимтгэлээ төлөх, урамшуулал авах, арилжааны тэмцээнд оролцох боломжийг бид нээж ажиллахаас гадна олон улсад үйл ажиллагаагаа нэвтрүүлж эхлэхээр зэхэж байна.

Бид DAX дээр секюрити токены арилжааг туршиж, Монголын анхны стэйблкойн болох MONT-ыг нэвтрүүлсэн билээ. Харин АрдМааний нь бидний хувьд төвлөрсөн бус санхүүгийн тогтолцоо руу нэвтрэх анхны оролдлого болсон бөгөөд 2022 оны туршид бид энэ төслийн ажлын явц, үр дүнг тухай бүрт нь танилцуулан ажиллана. Түүнчлэн бид Metaverse, NFT-г зах зээл

рүү гүн гүнзгий нэвтрэн оролцож эхлээд байна. Салбар нэгжүүд дээр очиж цаг үрэхгүйгээр

Банк санхүүгийн бүхий л үйлчилгээг нэг дороос авах боломжийг олгох зорилготой, 5 жилийн өмнө зах зээлд нэвтэрсэн **Ард Аппын 4 дэх хувилбарыг танилцуулснаар нэг сая хэрэглэгчийг татсан амжилтыг бид өнгөрсөн онд гаргалаа.**

Үүнийгээ дагаад манай компаниудын борлуулалт нэмэгдэж, ашиг ажиллагаанд сайнаар нөлөөлөв. Манай тэтгэврийн данс эзэмшигчдийн тоо 100 мянгыг давж, Ард Активын хөрөнгө 30 тэрбумд хүрсэн бол Монголын Хөрөнгийн Бирж дээр явагдсан хоёрдогч арилжааны дийлэнх хувь Ард Аппаар хийгдэв. Бид 25 мянган хүүхдэд АрдКидс Аппаа танилцуулж чадлаа.

Хувьцаагаа олон түмэнд түгээх үндсэн зорилгын хүрээнд 4 удаагийн хөрөнгө оруулалтын аян болон Хувьцаатай хүүхэд, Илгээлтийн Эзэд, Цахим Үндэстэн арга хэмжээгээр нийт 15,560 хөрөнгө оруулагчдад AARD 7.5 хувь, AIC 5.2 хувь, ADB 4.8 хувь болон TNGR, MNP, XOC-ын тодорхой хувиудыг нийт 13 тэрбум төгрөгөөр борлуулав. Үүний хажуугаар сул эх үүсвэр байсан тохиолдолд зарим хувьцаа эзэмшигчидтэй хэлэлцээр хийн, хувьцааг эргүүлж авах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд

нэгдлийн хэмжээнд 37.9 тэрбум төгрөгөөр AARD, 1.5 тэрбум төгрөгөөр AIC, 1.6 тэрбум төгрөгөөр ADB хувьцааг буцаан худалдаж авсан юм.

Мэдээж дээр дурдсанчлан, хүндрэл бэрхшээл, алдаа дутагдал ч их тохиолдов. Бидний төсөөлж чадаагүй өндөр ачааллын улмаас платформ, апп, вэбсайтууд маань гацах, хэрэглэгчдийг чирэгдүүлэх явдал олон гарсанд бид хүлцэл өчье. Манай багийнхан галыг унтраах хариу үйлдэл хийх, яаралтай арга хэмжээг өдөр шөнөгүй авч ажилласан ч тэр болгон амжилттай байгаагүйг онцлох хэрэгтэй. Бид техник технологийг сайжруулах чиглэлд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд харилцагч, хэрэглэгчийн үйлчилгээг төгөлдөржүүлэхээр тусдаа бие даасан Харилцагчийн Үйлчилгээний Төвийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэв.

Ардын хөрөнгө оруулалттай компаниудын нийт ажилчдын тоо 1,800 гаруй болсон бол шууд удирдлага дахь ажилчдын тоо 60 хувь буюу 100 гаруй хүнээр тэлэв. Ардын хуучин оффисыг ТэнГэр ТВ болон Unread Media-д зайчилж өгөөд Ардын бусад бүх компаниуд Сэнтрал Тауэр руу буурь сэлгэв. Харин манай харилцагчийн үйлчилгээний цахим төв Сансарт байрлах шинэ байранд оров.

Энэхүү шилжилтийн үеийг ашиглаж цахимаар харилцагчийн мөнгө хөрөнгийг луйвардах, манай системийн сул талыг

ашиглан, хулгай хийх явдал ч гарч байсныг бид дурдах ёстой. Энэ тал дээр бид технологийн түншүүдтэйгээ нягт холбоотой ажиллаж, хууль хүчний байгууллагуудаар асуудлыг шалгуулж байна.

Бид Богд банкинд хөрөнгө оруулах асуудлаар 8 сар хөөцөлдсөний эцэст татгалзахаас өөр гарцгүй болсон бол Канадын хөрөнгийн зах дээр гарах судалгааны ажил төдийлөн нааштай эерэг үр дүн авчирсангүй.

Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороонд гаргасан зөвшөөрлийн хүсэлт овоорч, бидний асуудлыг хойш нь тавьж, цааргалсан байдлаас болж, бид зах зээл дээрх олон боломжийг алдсаар байгааг энд цохон тэмдэглэе.

Бидний хамгийн ихээр харж хүлээж байсан хоёр хуулийн санаачилгын хувьд амин чухал нь болох Виртуал Хөрөнгийн Үйлчилгээг Үзүүлэгчийн тухай хууль УИХ – аар батлагдаж, харин Хувийн тэтгэврийн хууль тодорхой бус байдалтай үлдэв.

Маркетингийн хувьд Аппрентис Шоуны үр нөлөө үлэмж ихээр мэдрэгдсэн бөгөөд шоуны ялагч Ц.Бархас Нэгдлийн Маркетингийн ажлыг ахлан ажиллаж эхэлснийг дурдахад таатай байна. Бид Цахим Үндэстэн арга хэмжээний гол спонсороор ажиллаж, Альфа Урамшууллыг улс даяар зарлалаа. Ард Лизингийн хувьд

Өсдөг Машин хөтөлбөрийг эхлүүлсэн бол Илгээлтийн Эзэд аяныг хөдөө орон нутагт өрнүүлж, Ардын Брокерыг идэвхжүүлэв.

Бид нийгмийн хариуцлагын ажлуудаа улам өргөжүүлж, далайцтай болгох үүднээс санхүүгийн боловсрол, шинэ технологи, инновац, ногоон хөгжил, байгаль орчин, хүүхэд, урлаг, спортын чиглэлийн төсөл санаачилгуудыг дэмжин ажиллах

ХАСҮ буюу Хүчирхэг Ардын Сайн Үйлс ТББ-ыг үүсгэн байгуулаад байгааг бахархалтайгаар дуулгая.

Тухайлан дурдвал, цар тахлын ид дэгдэлтийн үед УОК-т дэмжлэг үзүүлэхээр Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагын Холбооноос санаачилсан хандивын аянд нэгдэж, мөнгөн тусламж үзүүлэхийн зэрэгцээ Гадаадад суугаа Монголчууддаа 1 тэрбум төгрөгтэй тэнцэх АрдКойны тусламжийг хуваарилан хүргэсэн билээ. Мөн халдвар тархалтын хамгийн эрсдэлтэй бүсэд ажилласан 100 сувилагчид 100 сая төгрөгийг хуваарилж, тус бүрт 1 сая төгрөг олгов. Мөн Улаанбаатар-Сонгдо эмнэлгээс хэрэгжүүлсэн Зүрх мартахгүй төслийг дэмжин оролцсон билээ.

Монгол Улсын өнцөг булан бүрт буюу 21 аймаг, 330 сумдад санхүүгийн боловсрол олгох зорилготой Илгээлтийн Эзэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутагтаа амарч буй оюутан залуусыг

цалинтай дадлага хийлгэсэн нь тэдний хувьд томоохон туршлага болсон юм. Цахим эринд хөл нийлүүлэн алхах үйлсэд түүчээлэх Digital Nation - 2021 арга хэмжээнд стратегийн түншээр оролцож, олон нийтийг цахим шилжилтэд уриалсан нь Ард Апп болон Ардын нийт бүтээгдэхүүнийг цахимаар авах хүсэлтэй иргэдэд таашаалтай үйл ажиллагаа болж чадсан билээ. Ard Students Challenge хөтөлбөрийг зарлаж, санхүүгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, мэргэжлийн карьераа эхлүүлэх боломжийг оюутан залуустаа олгож, идэвх оролцоог нь дэмжин ажиллаж байна. Эдийн засаг саармагжсанаас үүдэлтэйгээр төр засгаас хэрэгжүүлсэн ажлын байрыг цөөлөх бус тогтвортой хадгалах бодлогыг дэмжин хэрэгжүүлж, цар тахлын үед 121 ажлын байрыг бий болгосондоо баяртай байна. Мөн үндэсний хэмжээнд ТЭРБУМ МОД тарих хөдөлгөөнийг дэмжиж, Сонгинохайрхан дүүргийн Бумбатын булагт Ардын нэрэмжит төгөлтэй болсон нь бидний хувьд нэн таатай үйл явдал байв.

Бид холбоо харилцаагаа улам өргөжүүлж, Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банкнаас уламжлал болгон зохион байгуулдаг хамгийн том арга хэмжээ болох Санхүүг эмэгтэйчүүдийн төлөө ажиллуулах арга хэмжээний спонсороор ажилласанаар олон эмэгтэйчүүдэд итгэл өгсөн юм. НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд болох Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн

өсөлтийг дэмжих, Тэгш бус байдлыг бууруулахад нэгдэж, NO ONE LEFT BEHIND. TOGETHER. буюу ХЭН Ч ХОЦРОХ ЁСГҮЙ. ХАМТДАА. төслийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санхүү, хөрөнгийн зах зээлийн сургалтад хамруулах ажлаа эхлүүлээд байна. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй тамирчид болон тусгай хэрэгцээт боловсролын салбарыг дэмжин ажилласаар ирэв. Санхүүгийн үйлчилгээг зөвхөн насанд хүрэгчдэд хүргэх нь явцуу тул хүүхдийн санхүүгийн хэрэгцээг хангасан хамгийн анхны цогц аппликэйшн болох АрдКидсыг танилцуулав. Хүүхэд бүрийн ирээдүй гэрэлтэй байхыг билэгдэж, эх орны ирээдүй болсон хүүхэд багачууддаа криптовалютаар өв хөрөнгө бий болгож өгөх, ирээдүйд тэдний амьдралын эхлэл, санхүүгийн баталгаа болох үүднээс Монгол Улсын иргэн, 0-18 насны хүүхэд бүрт 77-100 АрдКойны хадгаламж үүсгэж өгснөөр бид ирээдүйн харилцагчаа бэлтгэж чадлаа гэж харж байгаа юм.

Эхэнд дурдсанаар миний мэргэжлийн амьдралд тохиолдсон хамгийн, хамгийн жил бол яах ч аргагүй 2021 он байв. Харин одоо Крипто өвөл хаяанд ирээд байна гэж харж байна. Яг л 2017 оны өвөл шиг... Тийм ч учраас Аваад март. АвДартаа хийгээд орхи гэдэг үг улам бүр хүчтэй нөлөөлөх болно. Энэ өвлийг давсан хүмүүс хожно. Ялагч болно. Энэ үйл явдал миний итгэж буй Азийн Чоно Эдийн Засаг болох

мөрөөдөлд том ахиц гаргах юм.

Бид 2022 онд явагдах банк санхүүгийн салбарын шинэчлэл, бүтээлч түйвээлтэд идэвхтэй оролцож, нэгдэх, нийлэх үйл явцыг идэвхийлэн эрэлхийлнэ.

СКОПА төсөл хөдөлснийг өнөөдөр би та бүхэндээ дэлгэж байна. Бид банкны үйл ажиллагааг илүү өргөн хүрээг хамарсан, хамгийн гол нь хүндээ хүртээмжтэй, шударга болгож, Монголын эдийн засгийн бүтээмжийг үүгээрээ дээшлүүлэх боломжтой гэж харж байгаа.

Бид хамтдаа том зорилго дэвшүүлээд, түүнийгээ чанартай хийж гүйцэтгэдэг. Урам зориг нэмдэг та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе!

Гүнээ хүндэтгэн мэхийн ёсолсон,

Таны хувь эзэмшдэг Ардын захирал
Хутагт овогтой Чулууны Ганхуяг

1

КОМПАНИЙН
ТУХАЙ



Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Корпорацийн бус байгууллага ХасБанкны нийт ажилчдад зориулан 600 сая төгрөгийг ажилчдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм. Улмаар ХасБанкны ажилчид тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-ГЭ ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийв.

ХАС-ГЭ ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэгдэл болж өргөжсөн юм.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь ХасБанкны үүсгэн байгуулагч, одоогийн Гүйцэтгэх Захирал Ч.Ганхуягийн санаачилгаар 2005 оны 9 сард Employee Investment Trust буюу И Ай Ти ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд Монголын анхдагч Институционал хөрөнгө оруулагч-ийн үндэс суурь ийнхүү тавигдсан түүхтэй.

И Ай Ти нь үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сан, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2021 оны жилийн эцсээр нийт Нэгдлийн хэмжээнд давхардсан тоогоор 62 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй болсноос гадна 1 ихнайд гаруй төгрөгийн хөрөнгийг удирдаж байна.

2013 онд гол хувьцаа эзэмшигчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд банк бус санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаасны компани, тэтгэврийн сан, хадгаламж зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагуудад тасралтгүй хөрөнгө оруулж, нэгдэх, нийлэх ажлыг явуулж, 2016 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч болж чадсан юм. 2017 онд үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын менежментийн компани, блокчэйн болон криптовалютын чиглэлээр ажиллах Ард Бит компани, Кripto Үндэстэн сан нэмэгдсэн бол 2018 – 2019 онуудад технологи, үл хөдлөх хөрөнгө, онлайн худалдаа, харилцагчийн үйлчилгээ, хөрөнгө оруулалт, лизингийн чиглэлээр

үйл ажиллагаа явуулах компаниуд байгуулагдаж, нэгдлийн бүтцэд багтаж эхлэв. 2020 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдах анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Санг байгуулсан. Харин криптовалютын сангийн чиглэлээр анхлан үйл ажиллагаа эрхлэх КriptoҮндэстэнг Булган Ундрага ХК-тай урвуу нэгдэл хийснээс гадна виртуал хөрөнгийн бирж болох DAX-ыг үүсгэн байгуулж, бүтцээ өргөжүүлэв. Ийнхүү 2021 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багцад нийт 42 компани багтаж байгаа ба тухайн онд бүтэцдээ нэгтгэсэн компаниудын талаар тус тайлангийн хөрөнгө оруулалт хэсгээс танилцаж болно.

Хүн бүр бүтээсэн баялгаасаа хувь хүртэх, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ бид хөтлөгдөн 2015 онд Ард Санхүүгийн Нэгдлийг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Жинст-Увс нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэж, Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн бол 2019 оны 8 сарын 8-нд Ард Санхүүгийн Нэгдэл нь урвуу нэгдэл хийснээр нээлттэй хувьцаат компани болсон юм.

Эрхэм зорилго

Хөрөнгө Оруулагч
Үндэстэнг цогцлооно.

Алсын хараа

Бүс нутагтаа тэргүүлэгч
финтек нэгдэл болох.

Мөрдөх зарчим

Хувьцаа эзэмшигчдийн эрх
ашгийг дээдэлж ажиллана;

Ёс зүйн хэм хэмжээг
өндөрт тогтоон дагаж,
хууль тогтоомжийг чандлан
мөрдөхийн зэрэгцээ
хүйсийн тэнцвэртэй
байдлыг хангаж ажиллана;

Хөрөнгө оруулалтын
өгөөж, эрсдэлийн харьцааг
зохистой түвшинд барьж
ажиллана;

Сайн засаглал, ил тод
байдлыг байгууллагын
бүх түвшинд нэвтрүүлэн
ажиллана;

Нээлттэй уян хатан
бодлого баримталж, зах
зээлийн мэдрэмжтэй,
хурдан шуурхай ажиллахыг
эрмэлзэнэ;

Шинийг нэвтрүүлж,
манлайлах бодлогыг
мөрдөж ажиллана;

Харилцагчийн үйлчилгээг
дээд зэрэгт барих бодлогыг
чандлан мөрдөнө;

Хамгийн авьяаслаг,
хүчирхэг, мэргэжлийн,
цомхон, үйл хэрэгтээ үнэнч
хамт олныг бүрдүүлж
ажиллах бөгөөд шинээр
ажилд орох босгыг өндөрт
тогтоож, ажлын байранд
тавигдах шаардлага,
хариуцлагыг чанд мөрдөнө;

Нийгмийн хариуцлага
өндөртэй, нийгэмд эерэг
өөрчлөлтийг түүчээлж
ажиллана;

Хууль эрх зүйн болон
бизнесийн орчиндоо
шаардагдаж буй
өөрчлөлтүүдийг бий
болгохын төлөө санаачилга
гаргаж ажиллана;

Байгаль орчин, эх
дэлхийгээ хайрлан
хамгаалах шилдэг
стандартыг нэвтрүүлж
ажиллана;

Бүтээгдэхүүн
үйлчилгээндээ өөрсдийн
итгэл үнэмшил,
философийг шингээж
ажиллана.

Давуу шинж чанар

Өрсөлдөх чадвар, үр
ашиг болон дэвшилтэт
технологийг цогцлуулсан
түншлэл;

Амжилттай хөрөнгө
оруулалтын туршлага, ил
тод засаглал;

Шинэ санаа, төслийг
хэрэгжүүлэгч олон улсад
танигдсан хамт олон;

Хөрөнгө оруулалтын
тогтвортой өгөөж;

Зах зээлийн боломжийг
хөрөнгийн үнэ цэн болгох
туршлага;

Хөрөнгө оруулагч
үндэстний танигдсан
брэнд;

Үндэсний хэмжээний цогц
дэд бүтэц;

Энтрепренёр соёл.

2

2021 ОНЫ ОНЦЛОХ
ҮЙЛ ЯВДАЛ



1 сарын 25

Хөрөнгө оруулалтын аян зохион байгуулав

2 сарын 9

Ард Санхүүгийн Нэгдлийн зах зээлийн үнэлгээ 100 тэрбум төгрөг давав

2 сарын 13

Ард Даатгал цэвэр ашгийнхаа 49% буюу 1 тэрбум, Ард Кредит 80% буюу 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэв

2 сарын 15

Ард Санхүүгийн Нэгдэл ХК хувьцаа эзэмшигчдэдээ 28.6 сая ширхэг АрдКойныг хувь тэнцүүлж хуваарилав

2 сарын 18

Ард Аппын 4 дэх хувилбарыг нэвтрүүлэв

2 сарын 25

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн зах зээлийн үнэлгээ 100 сая доллар давав

2 сарын 25

Ард Холдингс Интернэшнл болон Богд Банк стратегийн түвшинд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав

3 сарын 2

Ард Секюритиз ҮЦК нь Гацуурт компанийн 40 тэрбум төгрөгийн дүнтэй, 5 жилийн хугацаатай хаалттай бондыг гаргаж, санхүүжүүлэв



Ард Апп
БҮРТГҮҮЛЭХЭД ИЛҮҮ
ХЯЛБАР БОЛЛОО



**3 сарын 17**

Гадаадад гацсан Монголчууддаа туслах
Хүчтэй Хамтдаа төсөл хэрэгжиж эхлэв

3 сарын 26

НҮБ-ын тогтвортой хөгжлийн
зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлж
Монголын Хараагүйчүүдийн Үндэсний
Холбоо, JCI централ байгууллагуудтай
хамтран ажиллах санамж бичиг үзэглэв

4 сарын 1

Digital Assets Exchange буюу DAX нь
вэбсайт дээр суурилсан хувилбараа
нэвтрүүлэв

4 сарын 27

Ард нь Улаанбаатар Үнэт Цаасны Бирж
хувьцаат компанид (UBX)-д стратегийн
хөрөнгө оруулалт хийж, хамтран
ажиллахаар болов

4 сарын 30


Ардын нээлттэй компаниудын хувьцаа
эзэмшигчдийн хурал болов

5 сарын 1

АНУ-д үүсгэн байгуулагдсан, дэлхийн
шилдэг биржүүдийн нэг Bittrex Global
дээр АрдКойн арилжаалагдахаар болов



Хүчтэй. Хамтдаа.



ХӨРӨНГИЙН БИРЖ



Хүчтэй. Хамтдаа.

5 сарын 3

Ард Санхүүгийн Нэгдэл нь Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банктай (Women's World Banking) гэрээ байгуулж, тус нийгэмлэгийн гишүүн байгууллагаар элсэв

5 сарын 12

Ард Санхүүгийн Нэгдэл улаан бүсэд ажилласан 100 сувилагчид 100 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв

5 сарын 23

Илгээлтийн Эзэд – санхүүгийн боловсрол түгээх хөтөлбөр зарлагдав

6 сарын 1

Хүүхэд бүрт олгох 77 АрдКойн хөтөлбөрийг эхлүүлэв

6 сарын 18

АрдКойн Дэлхийн хамгийн том төвлөрсөн бус бирж болох Uniswar дээр бүртгэгдэж, арилжаалагдахаар болов

6 сарын 23

Ард Санхүүгийн Нэгдэл ХК, ГрэйпСити Монгол ХХК, МОСТ Финтек стратегийн түншлэлийн гэрээг 2017 онд байгуулж байсан бол дараагийн шатны хамтын ажиллагааг эхлүүлэв

7 сарын 1

Дижитал Хөрөнгийн Бирж буюу DAX.mn шинэчлэгдэж, олон улсын харилцагч бүртгэж эхэлснээр дэлхийд үйл ажиллагаагаа олон улсад тэлэв



7 сарын 2

Монголын медиа салбарын анхны олон нийтийн буюу хувьцаат компани болох зорилготой ТэнГэрЛиг Медиа Нэгдэл байгуулагдав

7 сарын 8

Ард Санхүүгийн Нэгдэл нь цахим спортын ZEUS багтай хамтран ажиллахаар болов

7 сарын 24

Төвлөрсөн бус санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн болох АрдМаанийг танилцуулав

7 сарын 31


Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Хүчтэй Ардын Сайн Үйлс буюу ХАСҮ санг үүсгэн байгуулж, үйл ажиллагаагаа эхлүүлэв

9 сарын 2

Үйл ажиллагаа, ашиг орлого, арилжааны идэвх, компанийн засаглалаараа тэргүүлэгч компанийг багтаадаг МХБ-ийн I ангилалд Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Кредит оров

9 сарын 3

Монголын хамгийн том шагналын сантай Ардын Альфа урамшуулал эхлэв



9 сарын 17

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж (UBX) нь олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулав

9 сарын 17

Цахим Алт 2 номын нээлт болов

9 сарын 17

Ард Санхүүгийн Нэгдэл нь Цахим Үндэстэн - 2021 арга хэмжээний Стратегийн түншээр ажиллав

10 сарын 7

Үндэсний хэмжээнд мод тарих хөдөлгөөнийг дэмжин ажиллаж, Сонгинохайрхан дүүргийн Бумбатын булагт Ардын нэрэмжит төгөлтэй болов

10 сарын 19

Хүүхдийн санхүүгийн хэрэглээнд зориулснаараа Монголдоо анхдагч АрдКидс Апп хэрэглээнд нэвтрэв



10 сарын 27

Ард Санхүүгийн Нэгдлийн нэгж хувьцаа тутамд 10 ширхэг АрдКойн буюу нийт 286,142,630 ширхэг АрдКойныг тусгаарлаж, хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр олгох Ухаалаг ногдол ашиг (Smart Dividend) хөтөлбөрийг зарлав

10 сарын 27

Унаж яваа машинаараа хөрөнгө оруулалт хийх онцгой боломжийг олгох Өсдөг Машин хөтөлбөр хэрэгжиж эхлэв

12 сарын 16

Монгол Улсын Их Хурал Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, холбогдох хуулийг батлав

12 сарын 29

Технологид хөрөнгө оруулагч оны онцлох компаниар шалгарав

3

ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
БҮТЭЦ

	2020	%	Өөрчлөлт	%	2021	%
1. И Ай Ти	733,349	2.60%	2,459,062	8.60%	3,192,411	11.20%
2. DAX (ARDT)*	1,000,000	3.50%	1,413,592	4.90%	2,413,592	8.40%
3. Бруно Рашле	2,098,592	7.30%	6,000	0.00%	2,104,592	7.40%
4. А.Сүхдорж	563,155	2.00%	1,304,222	4.60%	1,867,377	6.50%
5. Ардын Тэтгэврийн Данс	1,565,288	5.50%	153,659	0.50%	1,718,947	6.00%
6. Ард Холдингс Интернэшнл	2,874,410	10.00%	-1,403,991	-4.90%	1,470,419	5.10%
7. Г.Уянга	1,333,147	4.70%	48,789	0.20%	1,381,936	4.80%
8. Ч.Ганхуяг	1,264,519	4.40%	103,745	0.40%	1,368,264	4.80%
9. Ард Секюритиз	1,033,080	3.60%	-419,127	-1.50%	613,953	2.10%
10. Ард Лизинг		0.00%	603,571	2.10%	603,571	2.10%
11. Н.Мөнхнасан		0.00%	603,401	2.10%	603,401	2.10%
12. Ронкок Лимитед	479,111	1.70%	0	0.00%	479,111	1.70%
13. С.Гэрэлтуяа	455,717	1.60%	218	0.00%	455,935	1.60%
14. Ард Даатгал	417,905	1.50%	-6,450	0.00%	411,455	1.40%
15. С.Оргил	0	0.00%	383,800	1.30%	383,800	1.30%
Топ 15 хувьцаа эзэмшигчид	13,818,273	48.30%	5,250,491	18.30%	19,068,764	66.60%
Бусад хувьцаа эзэмшигчид	12,138,776	42.40%	-2,593,277	-9.10%	9,545,499	33.40%
Эргэлтэд буй хувьцаа	28,614,263	100.00%			28,614,263	100.00%
Хувьцаа эзэмшигчдийн тоо	4,779		14,255		19,034	
* ARDT секюрити токен эзэмшигчдийн тоо			6,591		6,591	

4

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Пүрэвжаргалын Батбаяр

ТУЗ-ийн дарга,
Ард Санхүүгийн Нэгдэл

ИБУИНВУ-ын Свонси хотын Уэлсийн их сургуулийг Эдийн засгийн бакалавр, Лондонгийн Бизнесийн Сургуулийг магистрын зэрэгтэйгээр тус тус амжилттай дүүргэсэн П.Батбаяр нь 20 жилийн хугацаанд Лондон болон Улаанбаатар хотод банк, санхүүгийн салбарт ажиллаж туршлага хуримтлуулсан нэгэн юм. Тэрээр ЕСБХБ-нд 10 орчим жил ажиллахдаа Монгол Улсад уул уурхай, нефтийн хөрөнгө оруулалтын төслүүд хариуцсан төлөөлөгчөөр, мөн Зүүн Европ, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд болон Монголыг хамарсан уул уурхай, газрын тосны салбар дахь хэд хэдэн томоохон, шинэ төслүүдийг судалж, санхүүжилтийн гэрээ хэлцэл байгуулах, хэрэгжүүлэх ажлыг гардан гүйцэтгэсэн. Түүний урьд нь гүйцэтгэж байсан бусад ажлуудаас дурдвал; Монгол Улсын тэргүүлэх арилжааны банкны нэг Хаан Банк, худалдаа, үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Интергрупп ХХК болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг Олова ХХК-д тус тус удирдах алба хашсан.

П.Батбаяр нь уул уурхайн зөвлөгөө, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг RMM Pty Ltd компанийн ТУЗ-ийн гишүүн болон Монголын Рагбигийн Холбооны Ерөнхийлөгчөөр давхар ажиллаж байна. 2014 оны 1 сараас Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, 2017 оны 8 сараас ТУЗ-ийн даргаар тус тус томилогдсон.



Чулууны Ганхуяг

Гүйцэтгэх захирал,
Ард Санхүүгийн Нэгдэл

Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэсэн тэрээр Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан Гүйцэтгэх захирлаар томилогдсон юм.

ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан түүхтэй. Ч.Ганхуяг нь ХасБанк байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдаар тус тус ажиллаж байв. Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн ТУЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн байна. Мөн Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчийн сонгуульт ажлыг давхар хашдаг. Ч.Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Бруно Рашле

Дэд дарга,
Шродер Адвек

Швейцарийн Холбооны Технологийн Институтыг барилгын инженерийн чиглэлээр, Стэнфордын их сургуулийн аж үйлдвэрийн инженер мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн бөгөөд 1990 онд Харвардын Их Сургуульд дэвшилтэт менежментийн хөтөлбөрийг дүүргэсэн Бруно Рашле 1997 онд Адвек Группыг үүсгэн байгуулж, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад 2017 онд компаниа Шродер Группд худалдсан байна. Шродер Адвек нь хувийн хөрөнгө оруулалтын менежментийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Тус компани нь харилцагч санхүүгийн байгууллагуудаас хуримтлуулсан 10 гаруй тэрбум долларын санг удирдаж, дэлхийн хэмжээнд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байна.

Адвекийг үүсгэн байгуулахаас өмнө Бруно Рашле нь Швейцарийн Мотор-Колумбусын сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ЭмСи Партнерс сангийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ. Тэрээр 5 тивд байрлах төрөл бүрийн аж үйлдвэрүүдийн төслийг эхлүүлэх, нэмэлт хөрөнгө оруулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төсөл хөтөлбөрийг удирдсан туршлагатай.



Авирын Сүхдорж

БСБ Сервис, ГрэйпСити Монгол,
МОСТ Финтек компаниудын үүсгэн
байгуулагч

ГрэйпСити Монгол ХХК, МОСТ Финтек ХХК-ийн ТУЗ-ийн дарга Украин улсын Киев хотын Политехникийн их сургуулийг Компьютерын инженер мэргэжлээр төгссөн А.Сүхдорж нь 1975 оноос Улсын Төлөвлөгөөний комиссоос ажлын гараагаа эхэлж төд удалгүй Монгол Улсын төв банкны Тооцоолон Бодох төвийн даргаар томилогдон ажиллаж байжээ.

Социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэний дараахан 1991 онд Монгол Улсын анхны мэдээллийн технологийн компани болох БСБ группыг үүсгэн байгуулсан байна. БСБ Группын ТУЗ-ийн дарга, ерөнхий захирлаар ажиллаж байх хугацаандаа 2000 онд банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн компани болох ГрэйпСити Монгол ХХК-ийг үүсгэн байгуулж, 2001 онд сансрын холбооны үйлчилгээ үзүүлэгч Инкомнет ХХК-ийг байгуулсан юм. ГрэйпСити Монгол нь эдүгээ Монгол Улсын банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн тэргүүлэгч компани болжээ.

Тэрээр Монголын Мэдээлэл Харилцаа Холбооны хөгжлийн түүчээлэгч бөгөөд банк санхүү, төлбөрийн секторын хөдөлгөгч хүч болсоор ирсэн билээ. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд олон тооны амжилттай төслүүд хэрэгжүүлсэн бөгөөд 2008 онд улсын хэмжээний анхны төлбөрийн үйлчилгээний оператор компанийг байгуулж (Мост Финтек ХХК), 2012 онд цахим төлбөр тооцооны МостМони мобайл хэтэвч үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.



Одончимэдийн Одбаяр

ТУЗ-ийн гишүүн,
Ард Даатгал ХК

Зөвлөлт Холбоот Улсын Киев хотын Багшийн Их Сургуульд багш мэргэжлээр суралцсан. Монгол Улсын магистрант зэрэгтэй. АНУ-ын Флорида мужийн Техникийн Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд олон улсын эдийн засагч, 1997-2000 оны хооронд Отгонтэнгэр Их Сургуульд хуульч, эрх зүйч, 2017 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуульд удирдлагын чиглэлээр тус тус суралцаж төгссөн.

О.Одбаяр нь Монгол Хятадын хамтарсан Төрийн Өмчит Улсын Үйлдвэрийн Газрын захирал, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Алтай Холдинг ХХК-ийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв. 2016 оноос Төрийн өмчит Эрдэнэс Монгол компанийн Бизнес хөгжлийн асуудал эрхэлсэн Дэд захирлын албыг хашиж, төрийн өмчит аж ахуйн нэгж, стратегийн холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгийг олборлох, боловсруулах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдийг удирдан түүний үр өгөөжийг баялгийн сангаар дамжуулан Монгол Улсын нийт ард иргэдэд хүртээх ажлыг хийж гүйцэтгэжээ.



Чулууны Мөнхбат

Ерөнхийлөгч,
Саусгоби Сэндс

ОХУ-ын Ленинград хотын Ддээд сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн ба Монгол Улсын Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистр, Шинэ Зеланд Улсын Вайкато их сургуульд Төрийн бодлого, удирдлагын чиглэлийн магистрын зэрэг хамгаалсан Ч.Мөнхбат нь Саусгоби Сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлаар 2015 оны 9 сарын 7-ны өдрөөс томилогдон ажиллаж байна.

Ажлын гараагаа Саусгоби Ресурс компанид Зөвлөхөөр ажиллаж эхлүүлсэн бөгөөд улмаар Саусгоби сэндс ХХК-ийн Засгийн газрын харилцаа, Бодлогын хэрэгжилт хариуцсан захирлаар ажиллаж байв. Үүний өмнө тэрбээр Азийн Хөгжлийн Банкинд Төслийн захирлаар, Дэлхийн Банкинд Зохицуулагчаар тус тус ажиллажээ. Ч.Мөнхбат нь Шинэ Зеландын Монгол Улс дахь Өргөмжит консул юм.



Мөнх-Очирын Сэргэлэн

Захирал,
Монгол Коосэн Технологийн Коллеж

Япон улсын Исити коллежийг менежментийн чиглэлээр, Бизнес, олон улсын дээд сургуулийг нягтлан бодогчоор тус тус төгссөн М.Сэргэлэн нь Техник Технологийн Дээд сургуулийн Ерөнхийлөгч, Монгол Коосэн Коллежийн захирлаар тус тус ажиллаж байна.

Тэрээр TCI компанийн захирал, MAC компанийн захирлаар тус тус ажиллаж байв. Харин Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат гишүүнээр 2018 оны 5 сараас ажиллаж эхэлжээ.



Михаил Зелдович

Хяналтын зөвлөлийн дарга,
Кокуун капитал

Харвардын Хуулийн сургууль болон Флетчерийн Хууль, Дипломатын сургууль төгссөн Михаил Зелдович хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт олгох, худалдааны хэлэлцээр хийх, зөвлөгөө өгөх ТУЗ-ийг удирдсан 20 гаруй жилийн туршлагатай, мэргэшсэн хөрөнгө оруулагч бөгөөд түүхий эдийн арилжаа эрхлэгч юм. Тэрээр 2.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтын сангийн менежерээр ажиллаж байсан ба Бостон Консалтинг Группын зөвлөх, АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын худалдааны хэлэлцэгчээр тус тус ажиллаж байв.

Одоогоор Михаил Зелдович нь Зүүн Өмнөд Азийн үр тарианы хөрөнгө оруулалтын сан Кокуун Капиталын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа ба ногоон технологи, хөдөө аж ахуйн технологи, цахим аюулгүй байдал, байгалийн баялгийн салбарт бие даан хөрөнгө оруулдаг.

Мөн дэлхийн зах зээл дээр түүхий эд арилжаалагч Трафигура компанийн бүс нутгийн тэргүүнээр 10 гаруй жил ажиллаж байна. Монгол Улсын эрчим хүчний хараат бус байдалд оруулсан хувь нэмрийг нь төрөөс өндрөөр үнэлж, түүнийг Алтан гадас одонгоор шагнажээ.



Арно Вентура

Удирдах партнер,
Гожо энд Компани

Арно Вентура нь бичил, жижиг бизнесүүд рүү чиглэсэн, Африк тив, Хятад улсад тэргүүлэгч дижитал бичил санхүүгийн групп болох Баобаб Группын үүсгэн байгуулагч билээ.

Баобабын эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдэдээ энгийн, амар хялбар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний боломж бололцоог нээхэд туслах явдал юм. 2005 онд МикроКред нэртэйгээр үүсгэн байгуулагдсан тус компани нь 2018 онд 1 тэрбум евротой тэнцэх санхүүжилтийг цахимаар болон мянга гаруй салбар, үйлчилгээний цэгүүдээрээ дамжуулан олгосон. Баобаб нь африк, хятадад үйл ажиллагаагаа явуулдаг 4,000 гаруй ажилтантай бөгөөд 1 сая орчим харилцагчтай.

Баобабыг үүсгэн байгуулахаас өмнө Арно Вентура нь Планет Финанс гэх олон улсын хөгжлийн болон бичил санхүүгийн салбарт тэргүүлэх олон улсын байгууллагыг үүсгэн байгуулахын сацуу Позитив Экономик Форум хэмээх нийгэмд чиглэсэн Европын томоохон чуулга уулзалтыг санаачлан, хамтран зохион байгуулж байв.

Арно 2005 онд Францын болоод 2013 онд Дэлхийн эдийн засгийн форумас Дэлхийн залуу удирдагч-аар тус тус нэрлэгдсэн байна.

Планет Финансыг үүсгэн байгуулахаасаа өмнө тэрээр Франц, Аргентинд БНП Парибас банкинд ажиллаж байсан бөгөөд Франц, Тайландад тэргүүлэх интернетийн үйлчилгээг ханган нийлүүлэгч компанийг үүсгэн байгуулах ажилд гар бие оролцжээ.

ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг (2020, 2021 он)

#	ТУЗ-ийн гишүүд	AIC		AARD		ADB	
		2020	2021	2020	2021	2020	2021
1	Чулуун Ганхуяг	9,561	57,019	1,264,519	1,368,205	714,785	887,885
2	Пүрэвжаргал Батбаяр	70,586	40,008	88,008	90,728		
3	Бруно Рашле	25,591	25,591	2,098,592	2,104,592		
4	Мөнх-Очир Сэргэлэн	17,407	945	56,432	62,335		
5	Одончимэд Одбаяр				7,091		
6	Авир Сүхдорж	149,749	203,994	563,155	1,226,377	5,086,580	5,086,580
7	Чулуун Мөнхбат	16,342	16,342	29,686	36,786		
8	Михаил Зелдович						
9	Арно Вентура					39,682	

#	ТУЗ-ийн гишүүд	BUN		TNGR		MNP	
		2020	2021	2020	2021	2020	2021
1	Чулуун Ганхуяг		3072		2,133	11,708	12,071
2	Пүрэвжаргал Батбаяр		129				
3	Бруно Рашле						
4	Мөнх-Очир Сэргэлэн		1				
5	Одончимэд Одбаяр		1				
6	Авир Сүхдорж		1				
7	Чулуун Мөнхбат						
8	Михаил Зелдович						
9	Арно Вентура						

5

УДИРДЛАГЫН БАГ



Чулууны ГАНХУЯГ
Гүйцэтгэх Захирал

Унгарын Будапешт хотын Корвинус
Эдийн Засгийн их сургууль

Санхүүч



**Жаргалангийн
АЛТАНГҮНИЙ**
Төр Засаг, Олон
Нийтийн Харилцаа
Эрхэлсэн Захирал

Тайваны Үндэсний Шинжлэх
Ухааны их сургууль

Бизнесийн удирдлагын мастер



Батбилэгийн ЗОЛБОО
Санхүү Эрхэлсэн
Захирал

АНУ-ын Нью-Йорк Мужийн их
сургууль

Санхүүч



**Энхсайханы
АМАРБАЯСГАЛАН**
Хөрөнгө Оруулалтын
Тэргүүн Банкир

АНУ-ын Индианагийн
их сургууль

Бизнесийн удирдлагын мастер



**Баярсайханы
ОЮУТЦЭЦЭН, АССА**
Эрсдэл Эрхэлсэн
Захирал

Их Британийн Лондон хотын BPP
их сургууль

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн
магистр



Цолмонгийн БАРХАС
Маркетинг Эрхэлсэн
Захирал

АНУ-ын Виржиниагийн Олон Улсын
их сургууль,

Бизнесийн удирдлага



**Мөнхбатын
МӨНХ-ЭРДЭНЭ
CPA, CPTA**
Дотоод Аудитор

Мандах Их сургууль

Аудитор, Мэргэшсэн нягтлан
бодогч



**Сүхбаатарын
АНАР-ЭРДЭНЭ**
Хянан Нийцүүлэлт
Эрхэлсэн Захирал

БНХАУ-ын Бээжингийн их
сургуулийн Хууль зүйн сургууль

Эрх зүйч



**Эрдэнэбат
БАЯРМАГНАЙ, COBIT-5
Certified**
Технологи Эрхэлсэн
Захирал

БНСУ-ын Жежү Үндэсний Их
сургууль

Компьютерын программ
хангамжийн инженер

6

ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ОРЧИН

Макро эдийн засаг

2008 оны санхүүгийн их хямралын дараах урт хугацаанд үргэлжилсэн дэлхийн эдийн засгийн өсөлт нь Ковид-19 цар тахлын дэгдэлтээс болж 2020 оны эхнээс зогссон. Хөл хорио, өвчин эмгэг, нас баралт нь эдийн засагт асар их хохирол учруулж, дэлхийн II дайнаас хойших хамгийн том эдийн

засгийн уналтыг авчирсан. Ковид-19 цар тахлын хоёр дахь жил буюу 2021 онд тэнцвэргүй, тодорхойгүй байдалд хүргэсэн эрсдэл их байсан ч нөхцөл байдалтай дасан зохицож, 2020 онд 3.1 хувийн уналттай байсан дэлхийн эдийн засаг сэргэж эхэлснээр 2021 онд 5.9 хувийн өсөлтийг үзүүллээ.

2020


3.1%

2021

5.9%

Цар тахал эхэлснээс хойш улс орнууд эдийн засгаа дэмжих зорилгоор төсөв, мөнгөний зөөлөн бодлогыг баримталж байсан ч уг арга нь дийлэнх улс оронд үр дүнгээ өгсөнгүй. Шинэ төрлийн коронавирус хувьсан өөрчлөгдөж байгаа тул дархлаажуулалтын явц, хувь хэмжээ, хүртээмжийн байдал нь бодлого боловсруулагчдад хүндрэл учруулсан. Мөн зарим улс орнууд хилээ нээж, олон улсын худалдаа сэргэж байгаа ч дархлаажуулалтын түвшин бага, вакцины хүртээмж хязгаарлагдмал орнуудын хил хаалттай байгаа нь нийлүүлэлтийн гинжин хэлхээг түгжсэн хэвээр байна.

Олон Улсын Санхүүгийн Корпорацийн дэлхийн бодит ДНБ-ийн өсөлтийн зураглал



2021 оны II хагаст эдийн засгийн олон салбарт инфляцын тасралтгүй өсөлт ажиглагдсан. Учир нь хөл хорионы дараа дэлхий даяар бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн ч улс орнуудын хилийн хаалт, хоригоос үүссэн нийлүүлэлтийн

хүндрэлээс болж, эцсийн хэрэглэгч дээр очиж буй үнэ огцом нэмэгдэж байна. Хэрэв энэхүү хандлага үргэлжилбэл инфляцын өсөлт нь эдийн засгийн сэргэлтийг сааруулж болзошгүй. 2020 онд Монголын эдийн засаг сүүлийн

10 жилд байгаагүй гүн хямралд орж 4.6 хувиар агшиж, төсвийн алдагдал ДНБ-ий 12 хувьтай тэнцэж байсан ч 2021 онд 1.4 хувиар тэлж сэргэлээ. Засгийн газар, Монголбанк хамтран иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, орон сууцжуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, малчдын орлого, тэдний амьжиргааг сайжруулахаар 2021 оны

2 сард Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх арван ихнайд төгрөгийн цогц төлөвлөгөө-г баталж, эдийн засгаа дэмжих арга хэмжээг үргэлжлүүлэн авсан юм. 2021 онд бодлогын хүүг 6 хувь дээр нь хэвээр хадгалсан. Харин мөнгөний нийлүүлэлт 27.8 ихнайд төгрөг болж жилийн хугацаанд 3.6 ихнайд төгрөг буюу 14.8 хувиар өссөн байна.



2021 онд төсвийн алдагдал өмнөх онтой харьцуулбал 34.5 хувиар буурч, 2.9 ихнаяд төгрөг болсон. Улсын төсвийн нийт орлого, тусламж өмнөх оноос 3.8 ихнаяд төгрөг буюу 36.5 хувиар өсөж 14.3 ихнаяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 12.7 ихнаяд болж өссөн бол Засгийн газрын зарлага, эргэн төлөгдөх цэвэр өр 12.2 хувиар өсөж 15.6 ихнаяд төгрөгт хүрчээ. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын нийт орлого 11.3 ихнаяд төгрөг болж, өмнөх оноос 2.8 ихнаяд төгрөг буюу 32.3 хувиар өссөн. Үүнд орлогын албан татвар 1.1 ихнаяд төгрөг буюу 48.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 673.1 тэрбум төгрөг буюу 42.4 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 628.2 тэрбум төгрөг буюу 28.4 хувиар, гадаад үйл ажиллагааны орлого 202.3 тэрбум төгрөг буюу 27.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин урсгал зардал өмнөх оноос 1.9 ихнаяд төгрөг буюу 17.8 хувиар өссөн нь зарлагын өсөлтөд нөлөөлсөн байна.

Монгол Улсын нийт гадаад өр жилийн хугацаанд 2.5 хувиар нэмэгдэж 33.2 тэрбум долларт хүрсэн нь ДНБ-ээс 2.2 дахин их байна. Харин Засгийн Газрын нийт гадаад өр 2 хувиар буурч 8.5 тэрбум доллар болсон нь ДНБ-ий 56 орчим хувьтай тэнцэж байна.

2020 оны эхний 11 сард төлбөрийн тэнцэл 9.3 сая долларын ашигтай байсан бол 2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 436.4

сая долларын алдагдалтай гарсан. Үүнд урсгал дансны алдагдал жилд 512.2 сая доллар буюу 86.9 хувиар өсөж, 1.1 тэрбум долларын алдагдалтай гарсан нь голчлон нөлөөлсөн.

Монгол Улс 2021 онд нийт 159 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 16.1 тэрбум доллар, үүнээс экспорт 9.2 тэрбум доллар, импорт 6.8 тэрбум доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 3.2 тэрбум доллар буюу 25.0 хувиар, экспорт 1.7 тэрбум доллар буюу 22.1 хувиар, импорт 1.5 тэрбум доллар буюу 29.2 хувиар тус тус өсөжээ. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ өссөнтэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өмнөх оноос 8.1 хувиар буурсан ч үнийн дүн 61 хувиар өсөж, 2.9 тэрбум доллар, нүүрсний экспорт 652.9 сая доллароор тус тус өссөн нь нийт экспортын өсөлтөд голлон нөлөөлжээ. Харин дизель түлшний импорт 157.7 сая доллароор, автобензин 146.4 сая доллароор, ачааны автомашин 116.2 сая доллароор, суудлын автомашин 87.8 сая доллароор тус тус өссөн нь импортын өсөлтөд түлхүү нөлөөлжээ. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум долларын ашигтай гарч, өмнөх оноос 121.1 сая доллар буюу 5.3 хувиар өсөжээ. 2021 онд БНХАУ-тай 10.2 тэрбум долларын

худалдааг хийсэн нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 63.1 хувийг эзэлж байна. БНХАУ руу экспортолсон бараа бүтээгдэхүүний 32.3 хувийг чулуун нүүрс, 38.0 хувийг зэсийн баяжмал эзэлж байна.

Хил нээгдсэн хэдий ч түүхий нефтийн үнэ нэмэгдэж, хөрш улс орны хил хаагдсаны улмаас тээвэрлэлт удааширч, тээвэрлэлтийн зардал нэмэгдсэн нь инфляц 13.4 хувьд хүрэхэд голчлон нөлөөлсөн бөгөөд инфляцийн өсөлтийн 46.3 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Мөнгө, санхүү

2020 онд Монголбанк бодлогын хүүгээ тогтмол бууруулж нийт 500 суурь пунктээр бууруулснаар 6 хувьд хүргэж, 2021 онд тухайн хувьд хадгалах бодлого баримталсан.

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны 12 сарын эцэст 27.8 ихнаяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.6 ихнаяд төгрөг буюу 14.8 хувиар өссөн. Үүнд валютын харилцах 362.0 тэрбум төгрөг буюу 18.3 хувиар, төгрөгийн харилцах 2.2 ихнаяд төгрөг буюу 63.7 хувиар, төгрөгийн хадгаламж 1.6 ихнаяд төгрөг буюу 11.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Монголбанк активын ангиллын шаардлагыг зөөлрүүлэх, хэрэглээний болон орон сууцны зээлийн хугацааг сунгах, банкны салбарын бизнесийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах түр арга хэмжээ авсан нь зээлдэгчид болон банкуудад үзүүлэх дарамт, ачааг бууруулсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 12 сарын эцэст 20.9 ихнаяд

төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.7 ихнаяд төгрөг буюу 21.3 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 50.8 хувийг иргэд, 47.0 хувийг хувийн байгууллага, 1.3 хувийг төрийн байгууллага, 0.9 хувийг санхүүгийн болон бусад байгууллага бүрдүүлж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл оны эцэст 938.1 тэрбум төгрөг болж, жилд 331.3 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар буурснаар нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.5 хувийг эзэлснээр өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурчээ. Чанаргүй зээлийн хувьд 2.1 ихнаяд төгрөг болж, жилд 71.5 тэрбум төгрөг буюу 3.6 хувиар өссөн ч нийт зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэнээр 10.0 хувийг эзэлж, 1.7 нэгж хувиар буурсан байна.

Хөрөнгийн зах зээл

Дэлхийн хөрөнгийн зах зээлийг илтгэх MSCI World Index 2021 онд 21.8 хувиар өссөнөөр дэлхийн хөрөнгийн зах зээл тасралтгүй 3 жил хоёр оронтой тооны өсөлт үзүүлээ. Вакцин нэвтрүүлэх өндөр хүлээлт, нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдалт, хагас дамжуулагчийн хомсдол, улс орнуудын эдийн засгаа дэмжих түүхэн их хэмжээний зарцуулалт болон хуримтлагдсан өр, Ковид-19 цар тахлын шинэ хувилбарууд, инфляцын өсөлт зэрэг зах зээлийг хөдөлгөх үйл явдлууд болсон бөгөөд технологи, хагас дамжуулагч, газрын тос, байгалийн хий, үл хөдлөх хөрөнгө болон хөрөнгийн менежментийн сектор хамгийн их өсөлттэй байсан бол үнэт металл олборлолт, Хятадын цахим худалдаа болон нарны сэргээгдэх эрчим хүчний сектор уналттай байлаа.

Нэгэнт цахимжих байсан шаардлагыг цар тахал хурдасгаж, дэлхийн цахимжих үйл явц шинэ түвшинд хүрсэн нь хүн бүрийн амьдралд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлсэн.

Тиймээс технологийн компаниуд 2021 оны хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн.

Технологийн аваргууд болох Alphabet (Google) 65 хувиар, Microsoft 51 хувиар, Apple 34 хувиар, Facebook 23 хувиар тус тус өссөн байна.

Хагас дамжуулагчийн хомсдол болон байнгын эрэлт хэрэгцээ нь хагас дамжуулагч үйлдвэрлэгчдэд давуу тал үүсгэсэн. Энэ салбарын тэргүүлэгч NVIDIA 125 хувийн өсөлт үзүүлжээ.

Газрын тосны үнэ ихээхэн савлаж жилийн хугацаанд баррель нь 50 доллараас 85 доллар хүртэл өссөн. Харин алт, мөнгөний зах зээл уналттай байсан нь үнэт металлын секторт ихээхэн нөлөөлөв.

БНХАУ дотоодын технологийн компаниуддаа хатуу хандаж эхэлсэн нь Alibaba, Baidu, JD.com, Pinduoduo зэрэг том компаниудад сөргөөр нөлөөлж, хувьцааны ханш хоёр оронтой хувиар унасан.

АНУ-ын хөрөнгийн зах зээл 2020 оны эхний улирал хүртэл огцом унаж, түүнээс хойш 2021 он хүртэл өссөн.

2021 оны дэлхийн хамгийн өндөр өсөлттэй зах зээлээр Монгол Улсын хөрөнгийн зах зээл тодорсныг олон улсын санхүүгийн байгууллагууд онцолсон. Монголын үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг

тодорхойлогч ТОП-20 индекс нэг жилийн хугацаанд 25,125.8 нэгжээр буюу 130.28 хувиар өссөн бөгөөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 98 хувиар өсөж, түүхэн дээд хэмжээ буюу 5.97 ихнаяд төгрөгт хүрсэн.

Уг өсөлтөө 2021 онд хадгалсан бөгөөд S&P 500, технологийн компаниудын үнэлгээг илтгэх NASDAQ, хамгийн том 30 компанийн зах зээлийн үнэлгээг илтгэх Dow Jones Industrial Average (DJIA) зэрэг голлох 3 индекс түүхэн өсөлтийг үзүүллээ. S&P 500 нь 21-р зуунд гурав дахь удаагаа нэг жилийн хугацаанд 26.9 хувиар өсөж түүхэн дээд өсөлтийг үзүүлжээ. Харин Apple, Microsoft, Nvidia, Tesla болон Alphabet зэрэг таван хувьцааны багц S&P 500 индексийн нийт өгөөжийн 32.6 хувийг бүрдүүлсэн.

2020 онд цар тахалтай холбоотой хөл хорио, хязгаарлалт Европын зах зээлд сөргөөр нөлөөлсөн ч 2021 онд Лондон (FTSE 100), Парис (CAC 40) болон

Франкфуртын (DAX 40) хөрөнгийн зах зээлийг илтгэх индексүүд бүгд хоёр оронтой тоогоор өсөжээ. Харин Токио (NIKKEI), Шанхай (SSE) болон Хонг Конгийн (HSI) биржийн индексүүд +5.6 хувь, +4.8 хувь, -14.1 хувийн өөрчлөлттэй байгаа нь Азийн зах зээл бусад зах зээл шиг тийм ч таатай байгаагүйг илтгэв.

Хөрөнгийн зах зээлийн арилжаа огцом идэвхжиж 1.4 ихнаяд төгрөгийн арилжаа хийгдсэн нь мөн адил түүхэн дээд хэмжээ байв. Нийт арилжааны үнийн дүнгийн 21.6 хувийг хувьцаа, 0.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 4 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 74.1 хувийг компанийн



бондын арилжаа эзэлсэн байна. Нэг ихнаяд орчим төгрөгийн дүнтэй компанийн бонд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаалагдав. Үүнд Эрдэнэс Таван Толгой компанийн бондыг олон нийтэд санал болгосон нь чухал нөлөө үзүүлжээ.

Мөн хувьцааны арилжаа нэг жилийн хугацаанд 6 дахин нэмэгдэж, 335 тэрбум төгрөгт хүрсэн. Уг өсөлтөд хадгаламжийн хүүгийн бууралт, эдийн засгийг дэмжих хөтөлбөр, үнэт цаасны зах зээлийн шинэ бүтээгдэхүүнүүд голлох үүрэг гүйцэтгэсэн.

Түүхий эдийн зах зээл

2020 онд цар тахал дэгдсэнээр дэлхийн эдийн засгийн өсөлт хүчтэй саарч, түүхий эдийн эрэлт буурснаар зах зээл уналтад орсон бол 2021 онд нөхцөл байдал дээрдэн эдийн засаг сэргэж, тээвэр логистик үргэлжилж эхэлсэн нь түүхий эдийн зах зээлд хүчтэй дэмжлэг үзүүллээ.

Мөн цар тахал гарсны нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн термометр гэгдэх газрын тосны ханш сүүлийн 20 жилийн хугацаанд хамгийн доод түвшинд хүрсэн төдийгүй 2020 оны II улиралд сөрөг ханшаар арилжаалагдсан байна. Тиймээс ханшийг дэмжихээр томоохон нийлүүлэгч улсууд газрын тосны гарцаа танасан. Харин өнгөрсөн 2021 онд дэлхийн голлогч газрын тосны ханш болох Брентийн үнэ 2015 оноос хойшхи хамгийн дээд түвшинд буюу 85 долларт хүрч, дунджаар жилийн 66 хувийн өсөлт үзүүллээ. Монгол Улсын хувьд нийт импортын 20 орчим хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлдэг тул уг өсөлт манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж, инфляц огцом өсөх хүчин зүйлсийн нэг болов.

Харин эрсдэлээс хамгаалагч гэгдэх алтны ханш эдийн засгийн өсөлттэй урвуу хамааралтай байдаг ба цар тахлын нөлөөгөөр 2020 онд түүхэн дээд үнэ болох 2,067 долларт хүрсэн. Гэвч ковидын эрсдэл буурч, төв банкууд

бодлогын хүүгээ өсгөн, мөнгөний хатуу бодлогод шилжиж эхэлснээр алтны ханш 1,700 долларт хүрч, дунджаар жилийн 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2020 онд алтны үнийн өсөлт болон хилийн хязгаарлалтаас шалтгаалан Монголбанк түүхэн дээд хэмжээ болох 23.6 тонн алт худалдан авсан бол 2021 онд 11.7 хувиар бууруулж 20.8 тонныг авсан байна. Ингэснээр 2020 онд төв банкны гадаад валютын албан нөөц 4.3 хувиар өсөж, 4.53 тэрбум долларт хүрсэн бол 2021 онд 3.7 хувиар буурч 4.37 тэрбум доллар болжээ. Өнгөрсөн онд 17.3 тонн алтыг 1 тэрбум доллараар экспортолсон нь 2020 онтой харьцуулахад хэмжээ болон нийт үнийн дүнгийн 43, 44 хувиар харгалзан буурч, нийт экспортын 11 хувийг бүрдүүлсэн байна.

2021 онд Монгол Улсын нийт экспортын 31 хувийг зэсийн экспорт бүрдүүлсэн ба зэсийн үнэ жилд 20 хувийн өсөлтийг үзүүлсэн. Уг өсөлтөд зэсийн хамгийн том хэрэглэгч болох Хятад улсын эдийн засгийн сэргэлт, зэсийн нийлүүлэлтийн

бууралт болон АНУ-ын дэд бүтцийг шинэчлэх 2 ихнайд долларын төлөвлөгөө дэмжлэг болсон. Манай улс 1.3 мянган тонн зэсийн хүдэр болон баяжмалыг 2.9 тэрбум доллараар экспортолсон нь 2020 онтой харьцуулахад хэмжээний хувьд 8 хувиар буурсан ч үнийн дүнгээр 63 хувиар өсчээ.

Мөн чулуун нүүрс манай улсын экспортын гол бүтээгдэхүүн ба 2021 онд нийт 16.1 мянган тонныг 2.8 тэрбум доллараар экспортолсон нь нийт экспортын 30 хувийг бүрдүүлж, тоо хэмжээний хувьд 2020 оноос 45 хувиар буурсан ч үнийн дүнгээр 30 хувиар өссөн байна. Хятад улсын хилийн хязгаарлалт чулуун нүүрсний экспортын хэмжээг

буурахад нөлөөлсөн бол Хятадын болон бусад улсын эдийн засгийн сэргэлт, Австралийн чулуун нүүрсний импортод тавьсан Хятад улсын хориг, үүнээс үүдсэн нийлүүлэлтийн хомсдол зэрэг хүчин зүйлс чулуун нүүрсний үнийг 3 дахин өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлэв.

Түүхий эдийн зах зээлийг ерөнхийлөн авч үзвэл 2021 онд эрчим хүчний бүтээгдэхүүний ханш огцом өсөж, үнэт металлын ханш буурч, ашигт малтмалын үнэ дунджаар жилийн 20-30 хувиар, газар тариалангийн бүтээгдэхүүн дунджаар 10 гаруй хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий түүхий эдийн 2021 оны эцсийн хаалтын ханш, түүний жилийн өөрчлөлт болон ханшийн график:



Валютын зах зээл

2021 оны эцэст гадаад валютын албан нөөц жилийн хугацаанд 3.71 хувиар буурч, 4.4 тэрбум доллар болсон байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн америк доллартай харьцах сарын дундаж ханш 2021 оны туршид тогтвортой байсан бөгөөд 12 сард 2,848.96 төгрөгтэй тэнцсэн. Төгрөгийн евротой харьцах сарын дундаж ханш 3,219.70 төгрөг болж, жилийн хугацаанд 7.1 хувиар чангарсан байна. Харин төгрөгийн юаньтай харьцах

сарын дундаж ханш 2021 оны 12 сард 447.38 төгрөг болж, жилийн хугацаанд 2.7 хувиар суларсан. Мөн төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш оны эцэст 38.62 төгрөг болж, тайлант хугацаанд 0.5 хувиар буурсан байна.

Үзүүлэлт	2019 оны 12 сар	2020 оны 12 сар	2021 оны 12 сар
Америк доллар	2,727	2,850	2,849
Жилийн өөрчлөлт	3.4%	4.5%	0.0%
Евро	3,031	3,466	3,220
Жилийн өөрчлөлт	0.9%	14.4%	-7.1%
Юань	389	436	447
Жилийн өөрчлөлт	1.5%	12.1%	2.7%
Рубль	43	38	39
Жилийн өөрчлөлт	10.8%	-11.4%	0.5%

Криптовалютын зах зээл

Ковид-19 цар тахлаас улбаалсан санхүү, эдийн засгийн уналт крипто зах зээлд 2020 оноос их хэмжээний савалгаа үүсгэсэн ч дэлхий нийтийн цахим шилжилттэй уялдан нийт крипто зах зээлийн үнэлгээ сүүлийн 2 жил дарааллан огцом нэмэгдсээр байна. Зах зээлийн үнэлгээ 2020 онд 190.9 тэрбум доллараас 760.7 тэрбум долларт хүрч, 4 дахин өссөн бол 2021 онд дээд цэгтээ 2.9 ихнаяд долларт хүрч, жилийн эцэст 2.2 ихнаяд доллар болсон нь жилийн хугацаанд 3 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм.

Биткойн нь крипто зах зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа бөгөөд 2022 оны 2 сард дангаараа 1 ихнаяд долларын зах зээлийн үнэлгээг давж, 3 сард түүхэн дээд ханш болох 65 мянга гаруй долларт хүрсэн.

Энэхүү өсөлт нь Биткойнд итгэх итгэл нэмэгдэж байгааг илтгэх бөгөөд томоохон санхүүгийн байгууллагууд болон **мэргэжлийн хөрөнгө оруулагч нар криптовалютын нөөц үүсгэж, нэмэгдүүлсээр байна.**

2021 оны 6 сард Эль Сальвадор улс Биткойныг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл болгох шинэ хуулийг баталж, Биткойныг гүйлгээнд нэвтрүүлсэн анхны улс болов. Харин Хятад улс төвлөрсөн бус криптовалютын эсрэг авах арга

хэмжээгээ үргэлжлүүлэн дотоодын бүх биткойн олборлогчдын үйл ажиллагааг зогсоож, криптовалютын гүйлгээг хязгаарласан хэдий ч өөрсдийн төв банкны цахим мөнгө болох дижитал юанийг хөгжүүлж, өвлийн олимпын үеэр хэрэглээнд нэвтрүүлсэн.

Криптовалют, токен нь блокчэйн платформын нэг хэрэглээ билээ. Харин 2022 онд NFT буюу дахин давтагдашгүй токен хэрэглээнд хурдацтай нэвтэрсэн. NFT дээр суурилсан цахим урлагийн бүтээлүүд олон төрөл, загвар, тоогоороо гарч тухайн зах зээлийг өсгөхөд голчлон нөлөөлсөн. Veerle нэрээрээ олонд танигдсан уран бүтээлч дэлхийн томоохон дуудлага худалдаа зохион байгуулагч Christie's-ээр дамжуулан өөрийн цахим бүтээлийг 69.3 тэрбум доллартай тэнцэх эфэриумаар

худалдсан. DappRadar аналитик платформын тайланд дурдсанаар 2021 онд NFT зах зээлд 23 тэрбум гаруй долларын арилжаа хийгдсэн байна. Мөн блокчэйнд суурилсан метаверс төсөлтэй холбоотой токены арилжаа 500 сая гаруй доллар хүрсэн бол тоглоом доторх эд хөрөнгийг NFT болгон 4.5 тэрбум доллараар арилжжээ.

Decentralized Finance (DeFi) буюу төвлөрсөн бус санхүүгийн зах зээл нь улам төгөлдөржиж, нийт зах зээлийн үнэлгээ нь 20 тэрбум доллараас 150 тэрбум доллар хүртэл өссөн байна. Шинэчилсэн хувилбар болох DeFi 2.0 нь төвлөрсөн бус санхүүгийн зах зээлийн цар хүрээг өргөжүүлэх боломжийг бүрдүүлсэн юм. Мөн стэйблкойны эрэлт хэрэгцээ нэмэгдсээр жилийн хугацаанд зах зээлийн үнэлгээ нь 5.5 дахин өссөн.

Монгол Улсад олон тооны криптовалют гарч, олон нийтээс их хэмжээний хөрөнгө татан төвлөрүүлэн, блокчэйн, NFT, санхүү, эрүүл мэндийн салбар гэх мэт өргөн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Ийнхүү

нийтээрээ криптовалют сонирхож, хөрөнгө оруулалт хийснээр дотоодын криптовалютын зах зээл огцом өссөн. Үүнтэй холбогдуулан Засгийн Газар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж батлуулсан. 2021 онд дотоодын зах зээлд 20 гаруй криптовалютын бирж, 50 орчим криптовалют гарч, олон нийтээс 500 тэрбум орчим төгрөгийг татан төвлөрүүлсэн ба дотоодын криптовалютын зах зээлийн үнэлгээ оргил үедээ 3 ихнайд төгрөгт хүрсэн. Нэг нэгнээ дагасан, экосистемээ бүрдүүлж чадаагүй, өндөр үнэлгээтэй, олон тооны криптовалютууд дотоодын жижиг зах зээл дээр гарсан нь эргээд зах зээлээ унагаах, хүмүүсийн итгэлийг алдах нөхцөлийг үүсгэсэн. 2018 оны Биткойны уналтаас Монголчууд бид крипто өвөл гэдэг ойлголттой болсон. Одоо Крипто өвөл дотоодын зах зээлд нүүрлээд байна. Эдгээр төслүүд өөрсдийн экосистемээ амжилттай бүрдүүлж, крипто өвөл-ийг давж гарах эсэх нь ойрын жилүүдэд тодорхой болно.

Гол үзүүлэлт

Орлогын дэлгэрэнгүй тайлан

(сая төгрөг)	2020	2021	Жилийн өөрчлөлт
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	688	2,030	2.9x
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	304	17,708	58.3x
Ногдол ашгийн орлого	1,312	1,004	-23.4%
Хөрөнгө оруулалтын багцын хүүгийн орлого	30	1,316	43.9x
Нийт хөрөнгө оруулалтын орлого	2,334	22,059	9.5x
Бусад орлого	917	784	-14.5%
Нийт орлого	3,251	22,843	7.0x
Борлуулалт, маркетингийн зардал	271	1,096	4.0x
Ерөнхий ба удирдлагын зардал	3,184	16,266	5.1x
Санхүүгийн зардал	2,876	3,346	16.3%
Бусад зардал	786	2,350	3.0x
Нийт зардал	7,117	23,058	3.2x
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(170)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		(27)	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,037)	(242)	94.0%
Орлогын татварын зардал (өгөөж)	(2)	(27)	-13.4x
Тайлант үеийн цэвэр алдагдал	(4,035)	(214)	94.7%
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгийн үнэлгээний олз	3,179	187,063	58.9x
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгөөс хэрэгжсэн олз	1,056	11,806	11.2x
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн	4,235	198,869	47.0x
Нийт дэлгэрэнгүй ашиг	200	198,655	991.6x

Санхүүгийн байдлын тайлан (тусдаа тайлан)

(сая төгрөг)	2020	2021	Жилийн өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	101	331	3.3x
Дансны болон бусад авлага	1,685	23,076	13.7x
Бусад санхүүгийн хөрөнгө	19	10,370	553.4x
Бараа материал	2	108	51.1x
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,244	3,708	3.0x
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,051	37,593	12.3x
Үндсэн хөрөнгө	466	645	38.5%
Биет бус хөрөнгө	8,941	59,160	6.6x
Ашиглах эрхтэй хөрөнгө	440	2,350	5.3x
Урт хугацаат хөрөнгө оруулалт	67,481	231,731	3.4x
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	77,329	293,886	3.8x
Нийт хөрөнгө	80,380	331,479	4.1x
Дансны болон бусад өглөг	4,552	28,704	6.3x
Богино хугацаат зээл	1,147	6,183	5.4x
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	11,958	3,685	-69.2%
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	350	980	2.8x
Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,007	39,552	2.2x
Хойшлогдсон татварын өр	3,405	24,189	7.1x
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	379	1,474	3.9x
Урт хугацаат зээл	409	6,633	16.2x
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	2,347	1,583	-32.6%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,540	33,879	5.2x
Өр төлбөрийн нийт дүн	24,548	73,431	3.0x
Дахин үнэлгээний нөөц	27,284	214,347	7.9x
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	0.0%
Хуримтлагдсан ашиг	1,359	12,145	8.9x
Эздийн өмчийн дүн	55,832	258,049	4.6x
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	80,380	331,479	4.1x

Санхүүгийн харьцаа үзүүлэлт (тусдаа тайлан)

Үзүүлэлт	2019	2020	2021	Жилийн өөрчлөлт
Хөрөнгө оруулалт/Хөрөнгө	87.86%	83.95%	69.91%	-14.04%
Хөрөнгө оруулалт/Өөрийн хөрөнгө	120.60%	120.86%	89.80%	-31.06%
Өр төлбөр/Хөрөнгө	27.67%	30.54%	22.15%	-8.39%
Санхүүгийн зардал/Нийт зардал	23.24%	40.59%	14.51%	-26.08%
Санхүүгийн зардал/Нийт өр, төлбөр	7.89%	11.77%	4.56%	-7.21%
Үйл ажиллагааны зардал/Нийт зардал	60.97%	37.60%	70.54%	32.94%
Үйл ажиллагааны зардал/Хөрөнгө	5.72%	3.33%	4.91%	1.58%
Цалингийн зардал/Нийт зардал	15.78%	21.81%	4.75%	-17.06%
Цалингийн зардал/Нийт орлого	10.20%	49.98%	4.80%	-45.18%


Нэгтгэсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2020	2021	Жилийн өөрчлөлт
Нийт компани	20	34	
Нэгтгэсэн нийт хөрөнгө (сая)	116,902	697,081	6.0x
Нэгтгэсэн дэлгэрэнгүй ашиг (сая)	13,892	193,751	13.9x
Нийт ажиллагсад	223	364	63.2%
Хувьцаа эзэмшигч	12,296	62,684	5.1x
Ард Апп хэрэглэгч	637,000	990,071	55.4%
АрдКойн эзэмшигч	286,117	516,425	80.5%
Даатгуулагч	166,509	235,470	41.4%
Зээлдэгч	37,694	47,303	25.5%
Тэтгэврийн данс эзэмшигч	10,500	100,600	9.6x
Үнэт цаасны данс эзэмшигч	89,305	146,893	64.5%
ХЗХ-ны гишүүд	1,062	2,678	2.5x

Үнэлгээ

(сая төгрөг)	Аргачлал	2020У4	%	2021У4	%
Стратегийн хөрөнгө оруулалт		67,449		378,912	
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	17,689	23.7%	31,727	23.6%
Ард Даатгал (MSE: AIC)	MV	13,108	65.5%	14,970	45.4%
Ард Кредит (MSE: ADB)	MV	14,080	61.3%	25,009	40.6%
Ард Секюритиз	BV	2,305	100.0%	14,239	90.0%
Ард Менежмент	BV	1,265	100.0%	6,924	90.0%
Ард Актив	BV	99	9.5%	735	9.4%
Ард Лайф	BV	11,426	100.0%	33,217	95.0%
Ард Лизинг	BV			10,766	100.0%
ТэнГэр Системс	BV	1,154	100.0%	10,482	100.0%
Ард Холдингс Интернешнл	BV	6,324	100.0%	15,002	100.0%
Ард Пропертиз	BV			18,211	100.0%
Ард Бит	MV of ARDX			84,023	100.0%
DAX	DCF			45,000	60.0%
Даац хөрөнгө оруулалт (54% of UBX)	LT			4,096	51.0%
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	MV			57,780	41.8%
ГрэйпСити Монгол	LT			9,000	45.0%
Мост Финтек	LT			4,500	45.0%
Тактикийн хөрөнгө оруулалт		50		26,058	
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)	MV	3	0.1%	19	0.2%
Булган Ундрага (MSE: BUN)	MV	28	32.9%	5,319	28.5%
Бусад өмч болон бонд		19		10,370	
Бусад		-8,263		24,643	
Үндсэн болон биет бус хөрөнгө		9,407		62,321	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		101		331	
Бусад цэвэр хөрөнгө		-17,771		-37,843	
Нийт үнэлгээ		59,236		429,612	
Эргэлтэд байгаа хувьцааны тоо		27,175,629		28,614,263	
Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)		2,180		15,014	

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа



MSE: **ADB** **+168%**

MSE: **XOC** **+99%**

MSE: **MNP** **+111%**

MSE: **AIC** **+68%**

MSE: **BUN** **+18,746**

MSE: **TNGR** **+790%**

	AARD	AIC	ADB	XOC	BUN	TNGR	MNP	MSE ¹
Нээлт	1,699	800	82	100	109	2,247	640	19,082.37
52 д/х доод-дээд	1,628-12,750	720-1,749	77-351	107-654	875-224,300	2,247-36,700	875-1,903	19,024-49,252
Хаалт	9,785	1,319	220	199	164,900	20,000	1,350	44,411
Зах зээлийн үнэлгээ (тэрбум)	280	33	62	10	19	120	134	
Хувьцааны эргэлт	33%	34%	38%	52%	47%	38%	1%	8.79% (Дундаж)
Арилжааны дүн (тэрбум)	72.2	10.5	19.7	6.9	2.9	14.7	1.1	
МХБ-ийн арилжаанд эзлэх хувь	33%	4.7%	8.6%	74%*	1.3%	6.4%	0.5%	

Монголын Хөрөнгийн Биржийн 2021 оны нийт арилжаанд

Ард Санхүүгийн Нэгдлийн компаниуд **хамгийн өндөр өсөлтийг үзүүлж, арилжааны идэвхээр тэргүүлэв.**

2021 онд Ард Даатгал (AIC), Ард Кредит (ADB), Үндэсний Хувьчлалын Сан (ХОС), Монгол Шуудан (MNP), Булган Ундрага (BUN), ТэнГэрЛиг Медиа Нэгдэл (TNGR) компаниудын хувьцааны үнэ хамгийн багадаа 165 хувиар өссөн ба 33-52 хувийн эргэлттэй байлаа. Хөрөнгийн биржийн ТОП-20 индексэд багтдаг компаниудын хувьцааны эргэлтийн дундаж нь 8.8 хувь байсантай

харьцуулбал Ардын компаниудын хувьцаа хамгийн эрэлттэй, хөрвөх чадвар сайтай байв. Мөн Ард Санхүүгийн Нэгдэл нь дангаараа Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны арилжааны 33 хувийг бүрдүүлсэн бол Ардын нээлттэй компаниудын арилжааны 55 орчим хувийг бүрдүүлж чаджээ. Харин Үндэсний Хувьчлалын Сан нь сангийн арилжааны 74 хувийг бүрдүүлжээ. Монголын үнэт цаасны зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй 30 компани нийт хөрөнгийн зах зээлийн 93.73 хувийг бүрдүүлдэг бол Ард Санхүүгийн Нэгдэл дангаараа 4.7 хувийг, Ардын нээлттэй хувьцаат компаниуд 11 орчим хувийг бүрдүүлж байна.

Гүйцэтгэлийн тайлан

Технологи

АрдКидс Апп

Ард Санхүүгийн Нэгдэл нь хүүхдийн санхүүгийн хэрэгцээг хангасан, хамгийн анхны цогц аппликэйшн болох АрдКидс Аппыг 2021 оны 10 сарын 14-нд танилцуулсан.

Уг апп нь хүүхдэд санхүүгийн харилцаанд зөв зохистой оролцох боломжийг нээж өгөхөөс гадна **санхүүгийн боловсролыг багаас нь олгох зорилготой юм.**

Өөрийн АрдКидс Аппаараа Хадгаламж, Үнэт цаас, АрдКойны дансаа хянах, эцэг эхээс зөвшөөрсөн мөнгөн дүнгийн зарцуулалт хийх, санхүүгийн мэдлэгээ

Дэд бүтцийн шинэчлэлт

Ард Аппын тасралтгүй ажиллагаа, найдвартай байдлыг хангах, хэрэглэгчдэдээ шуурхай үйлчилгээг хүргэх зорилгоор үндсэн системийнхээ хатуу дэд бүтцийг бүхэлд нь шинэчилж, системийн ачааллын даацыг нэмэгдүүллээ.



тэлэх, мэдээлэл авах болон хүүхдийн онлайн шопоор үйлчлүүлэх боломжтой. 2021 оны эцэст 22,113 хүүхэд АрдКидс Аппын хэрэглэгч болжээ.

Системийн тасралтгүй ажиллагааг хангахын зэрэгцээ Монголбанкны Цахим Мөнгөний журмын шаардлагыг биелүүлж, үндсэн системийн өргөтгөл бүхий нөөцийн төвийг бий болголоо. Мөн 2022 онд нөөцийн төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Дархан хотод нөөц төвийг шилжүүлэн байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Технологи


Ард Аппын хэрэглэгчийн баталгаажуулалт, аюулгүй байдлын сайжруулалт

Монголбанкнаас тавьсан шаардлагын дагуу ХҮР системтэй холболт хийсэн ба хэрэглэгч Ард Аппаар хурууны хээгээ уншуулан өөрийн бүртгэлийг цахимаар баталгаажуулж, KYC буюу харилцагчаа таньж мэдэх боломжтой болсон. Ингэснээр хэрэглэгч салбар дээр очих шаардлагагүйгээр өдрийн гүйлгээний лимитээ өсгөх таатай нөхцөл сэн.

Мөн хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал болон Ард Аппын системийн аюулгүй байдлыг сайжруулж, найдвартай үйлчилгээг хүргэхээр дараах сайжруулалт болон шинэчлэлтүүдийг хийлээ.

2022 ондоо хэрэглэгчийн танилт нэвтрэлтийн ДАН системийг нэвтрүүлж,

2022 оны 5 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Цахим гарын үсэг, Кибер аюулгүй байдлын тухай болон бусад багц хуулиудтай нийцүүлэн аюулгүй, цогц цахим үйлчилгээг улам бүр төгөлдөржүүлэхээр бэлтгэл ажил хангагдаж байна.



Дансны Нэгдсэн Санд холбогдлоо

Ард Аппын үндсэн систем Монголбанкны бага дүнтэй Автомат Клиринг Хаус шинэ төлбөрийн систем АСН+, төлбөрийн системийн дэд систем болох Дансны Нэгдсэн Санд холбогдлоо. Дансны нэгдсэн сан нь хэрэглэгчийн дансны нэр, дугаар гэсэн үндсэн мэдээллийг утасны дугаар, цахим хаяг гэх мэт дахин давтагдашгүй мэдээлэлтэй холбон бүртгэлжүүлэх, системийн оролцогчдын дансны

мэдээллийн сангаас лавлагаа авах, банк хоорондын төлбөр тооцоонд ашиглах боломжтой систем юм. Ингэснээр хүлээн авагчийн дансны нэр, дугаар зөрөх алдаанаас үүдэлтэй гүйлгээ амжилтгүй болох эрсдэл буурна. Мөн харилцагчийн болон банкны нэр, дансны дугаар зэрэг мэдээллүүдийг нэгтгэсэн, дахин давтагдашгүй мэдээллийг ашиглан хялбар аргаар гүйлгээ хийх давуу талтай.

QR код ашиглан төлбөр, шилжүүлэг хийх

Ард Аппын QR код уншигч нь Ардын дансны суурьтай QR кодоос бусад кодыг унших боломжгүй гэсэн асуудлыг шийдвэрлэж төлбөр хийх, мөнгө шилжүүлэхэд хялбар болсон. Тодруулбал, Монгол Улсад хэрэглээгээрээ хамгийн өргөн тархсан

QRay системийн суурьтай QR кодыг унших боломжтой боллоо. Ингэснээр Ард Аппын хэрэглэгч дэлгүүр, ресторан, худалдааны газрууд, онлайн шоп, такси зэрэг бүхий л газарт төлбөр тооцоогоо хялбараар буюу QR кодыг уншуулан хийх нөхцлийг бүрдүүлсэн.

Урамшуулал цэс

Ард Аппад Урамшуулал цэсийг шинээр нэмлээ. Ард Аппын хэрэглэгч үйлчилгээ авах, төлбөр хийх, шилжүүлэг хийх тутамд урамшууллын АрдКойн цуглардаг. Хэрэглэгч урамшууллаар авсан койноос гадна, өөрийн худалдан

авсан койн, HODL хийсэн койн зэргээ данс тус бүрээр нь ялган харж, удирдахаас гадна Койн шилжүүлэг хийх, HODL хийх, койн авах боломжуудыг нэмсэн.

UBX бирж

UBX биржийг Ард Апптай холболт хийв. Ингэснээр хэрэглэгчид Ард Аппаар дамжуулан UBX платформ дээр үнэт цаасны арилжааг шууд хийх боломжтой.

Тодруулбал, Ард Аппын хэрэглэгч нь UBX болон МХБ-ээс сонгох буюу нэг сувгаас хоёр бирж дээр арилжаа хийнэ гэсэн үг.

URG койн холболт

Ард Аппыг URG койнтой холбосон. Ингэснээр хэрэглэгчид Өргөө кино театраас тасалбар захиалахдаа нийт

үнийн дүнгийн 50 хүртэлх хувийг URG эсвэл АрдКойноор төлөх боломжтой.

Маркетинг

Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай хүргэх нь бидний зорилготой нийцэх тул сошиал медиаг ашиглан мэдээ, мэдээлэл дамжуулахад түлхүү анхаарав. Жил бүр зохион байгуулдаг хувьцаа эзэмшигчдийн хурал, жилийн тайлан, улирлын тайлангаа эрхэм хувьцаа эзэмшигч, харилцагчдадаа цахимаар саадгүй хүргэж ажиллав.

Мөн Ard Talk Show-аар 7 хоног бүр санхүүгийн зах зээлийн тойм мэдээг хүргэж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ Ардын влогоор

сурталчлан, урамшуулалтай холбоотой болон цаг үеийн мэдээллээ Facebook Live хэлбэрээр зохион байгуулах зэргээр сошиал медиад зориулсан сонирхолтой бүтээлүүдийг амжилттай гаргаж, 1 сая гаруй хэрэглэгчдэд хүргэсэн. Цаашид мэргэжлийн, ахисан түвшний хэрэгсэл, нөөц, судалгааг ашиглан дижитал маркетингийн үйл ажиллагааг улам нарийсгаж, сайжруулах боломж бололцоог нэмэгдүүлсээр байна.

Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай хүргэхийн тулд 2021 оны 3 сард Ард Кредит компанийн Харилцагчийн Үйлчилгээний

Төвийг бие даасан компани болгон өргөжүүлж Ард Суппорт компанийг үүсгэн байгуулсан. Одоогоор уг компани нь 5 алба нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны тайлан:

- 2021 онд Лавлах үйлчилгээний шугамаар 1 сая харилцагч хандсан ба 80-90 хувьд нь үйлчилгээ үзүүлэв
- Нийт 50,783 гомдлын 44 хувьд анхны хандалтаар үйлчилгээ үзүүлж, нийт гомдлын 99.6 хувийг бүрэн барагдуулав
- Хагас жилийн хугацаанд даатгалын шуурхай албаны шугамаар 4,379 харилцагчид үйлчлэв
- Танхимаар болон цахимаар 115 удаагийн сургалт зохион байгуулав
- Сошиал шугамын үйл ажиллагааг өргөжүүлэн, Many Chatbot автомат хариулагчийг нэвтрүүлсэн. Хамгийн их хандалттай, лавлагаа үйлчилгээний 48 төрлийн Chatbot хөгжүүлснээр нийт хандалтын 42 хувьд хүрч үйлчлэв.

Аппрентис Монгол



Санхүү, бизнесийн салбарт салхи оруулахыг зорьж, Монгол ТВ - тэй хамтран бүтээсэн Аппрентис Монгол Шоу нэвтрүүлэг 2021 оны 2 сард хаалтаа хийж, үзэгч түмний сайшаал, магтаал хүртэхийн зэрэгцээ

Санхүү, бизнесийн мэдлэг боловсролыг түгээхэд томоохон ач холбогдол бүхий бүтээл болсныг нийт харилцагч, үзэгчдийн зүгээс илэрхийлэв.

Тус нэвтрүүлгээр бид Ардын Тэтгэврийн Дансны хувийн тэтгэврийн хуримтлал, санхүүгийн бүхий л хэрэгцээг нэг дор багтаасан Ард Апп, түүнийг дагалдах АрдКойн болон Ард Даатгалын бүтээгдэхүүн болох АрдМэнд зэрэг

үйлчилгээг олон нийтэд танилцуулсан билээ.

Нэвтрүүлгийн ялагч Ц.Бархас Ард Холдингс Интернэшнл компанийн Гүйцэтгэх Захирлаар томилогдож, Ард Санхүүгийн Нэгдлийн Маркетинг Эрхэлсэн Захирлын албан тушаалыг давхар хашиж байна. Мөн Аппрентис Монгол Шоуны шилдэг оролцогч О.Амарболд Ардын эгнээнд нэгдэж 2021 оны Ардын Тэтгэврийн Данс компанийн өсөлтийг өрдөхөд онцгой үүрэг гүйцэтгэсэн бол 2022 ондоо зөвшөөрлөө авч үйл ажиллагаагаа эхлэх амьдралын даатгалын шинэхэн компанийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллахаар боллоо.

Цахим Үндэстэн - 2021 арга хэмжээний Стратегийн түншээр ажиллалаа




Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хамгийн том арга хэмжээ Цахим Үндэстэн нь 2021 оны 9 сарын 17-ноос 19-ны хооронд Үндэсний соёл, амралтын хүрээлэн-д зохион байгуулагдаж өндөрлөсөн. Технологид суурилсан шилдэг бүтээгдэхүүн, онцлох үйлчилгээнүүдтэй нэг дороос танилцах боломж олгодог тус арга хэмжээний үеэр Ард Санхүүгийн Нэгдлийн асар олон шинэлэг үйл ажиллагааг зохион байгуулав. Арга хэмжээнээс онцлон дурдвал, Монголын Үнэт Цаасны Биржийн (UBX) платформын нээлт, Цахим алт номын шинэчлэн найруулсан 2 дахь хэвлэлийн нээлт, Илгээлтийн

Эзэд төслийн хаалтын арга хэмжээ зэргийг амжилттай зохион байгууллаа.

Нийт 3 өдрийн турш үргэлжилсэн арга хэмжээний үеэр бид **өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ 100,000 гаруй хүнд хүргэж чадсан.**

Мөн Цахим Үндэстэн арга хэмжээнд зориулан тэтгэврийн хуримтлал, хувьцаа, хадгаламж, даатгалын бүтээгдэхүүн бүхий хөрөнгө оруулалтын багцыг харилцагчдад санал болголоо.

Монголын хамгийн том шагналын сантай Ардын Альфа урамшуулал



Монголын хамгийн том шагналын сантай Ардын Альфа урамшуулал зарлагдлаа. Энэхүү урамшуулал нь Та хөрөнгө оруул. Харин бид таныг урамшуулъя уриан дор 2021.8.31- ээс 2022.2.28-ны хооронд нийт 6 сарын хугацаанд үргэлжилсэн. Манай бүтээгдэхүүн үйлчилгээг авч урамшууллын эрх цуглуулсан хэрэглэгчид дундаас сар бүр Lada Ves-

ta, 1 бүхэл Эфэриум, 3 сая төгрөгийн хувьцааны эздийг шалгаруулахаас гадна урамшууллын төгсгөлд

Супер шагнал болох Land Cruiser 300, 1 бүхэл БитКойн, 100,000,000 төгрөгийн хувьцааны эздийг тодруулсан.

Өсдөг Машин



Автомашины үнэлгээ жил бүр буурна уу гэхээс өсдөггүй. Харин Ард Санхүүгийн Нэгдлээс хэрэгжүүлсэн

Өсдөг Машин төсөл таны унаж буй **автомашины үнэлгээг жил ирэх тусам өсөх боломжтой нөхцөлийг шинээр бий болгосон**

Унаж яваа автомашинаараа хөрөнгө оруулалт хийгээд ирээдүйн хөрөнгөө баталгаажуулах, цаашлаад өсгөх боломжтой юм.

Өөрөөр хэлбэл, унаж яваа автомашиныхаа үнэлгээнд дүйцэхүйц хэмжээний АрдКойн болон Ардын хувьцаануудад хөрөнгө оруулна гэсэн үг.

Олон улсад цар хүрээгээ тэлж ажиллав

Бид Канадын Маркетингийн агентлаг M&C болон түүний түнш зөвлөхүүдтэй Канад дахь PR, Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр компанийн хувьцаагаа гарах боломж бололцоо, АрдКойны танилцуулга, нийгмийн хариуцлагын хүрээний төсөл хэрэгжүүлэх тухайд хамтран ажилласан.

Үүнтэй холбоотойгоор гадны зах зээл, нийгэмд ил тод байх зорилго бүхий Гүйцэтгэх Захирлын ganhuuag.com вэбсайтыг бэлэн болгоод байна. Үүнд товч намтар, боломжит хөрөнгө оруулагчдыг татах зорилго бүхий хувь хүний нөлөөллийн түүхүүд, мөн Ард Санхүүгийн Нэгдэл болон нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг компаниудын жагсаалтыг багтаасан болно. Уг вэбсайтыг мөн Монгол, Франц, Хятад, Орос хэлээр орчуулан гаргах юм.

Канадын хөрөнгийн зах зээлд хөл тавих тухайд, бид зохих шалгалт, судалгаануудыг хийсний дараа олон улсын бирж дээр гарах нь одоогоор оновчтой биш байна гэдэг дүгнэлтэд хүрсэн.

Мөн нийгмийн хариуцлагыг эрхэмлэгч компанийн хувьд Global Dignity-тэй хамтран, сайн үйлсийг АрдКойноор урамшуулдаг чатбот ажиллуулахаар төлөвлөж байна. Уг чатботыг 2022 оны хавраас эхлээд Канадад, дараа нь дэлхий дахинд танилцуулахыг зорин ажиллаж байна.

Нийгмийн хариуцлага

Цар тахлын ид дэгдэлтийн үед УОК-т дэмжлэг үзүүлэхээр Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагын Холбооноос санаачилсан хандивын аянд нэгдэж, мөнгөн тусламж үзүүлснээс гадна Гадаадад гацсан Монголчууддаа сэтгэлийн дэм өгөх Хүчтэй, Хамтдаа төслийн хүрээнд 1 тэрбум төгрөгтэй тэнцэх АрдКойны тусламжийг бүртгэгдсэн иргэдэд хуваарилан хүргэсэн билээ.

Мөн цар тахлын хамгийн эрсдэлтэй буюу улаан бүсэд ажилласан 100 сувилагчид 100 сая төгрөгийг хуваарилж, тус бүрт 1 сая төгрөг олгосон нь эх орон, иргэдийнхээ эрүүл мэндийн манаанд хатан зориг гарган зүтгэдэг тэдэнд бодитой дэмжлэг үзүүлсэн нь нүдээ олсон ажил болсныг оролцогч бүх талуудаас илэрхийлж байв.

Эдийн засгийн өсөлт саармагжсанаас үүдэлтэйгээр төр засгаас хэрэгжүүлсэн ажлын байрыг цөөлөх бус тогтвортой

хадгалах бодлогыг дэмжин хэрэгжүүлж, цар тахлын үед нэгдлийн хэмжээнд 121 ажлын байрыг бий болгов.

Үндэсний хэмжээнд ТЭРБУМ МОД тарих хөдөлгөөнд нэгдэж, Сонгинохайрхан дүүргийн Бумбатын булагт Ардын нэрэмжит төгөлтэй болсон нь бидний зүгээс байгаль орчиндоо ээлтэй байхыг мөр зэрэгцэн ажиллаж яваа салбар нэгтнүүд болон нийт Монголчууддаа уриалсан, нэн таатай үйл явдал байв.

Монголчууддаа санхүүгийн боловсролыг үнэ төлбөргүй, хүртээмжтэй түгээх Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Орон даяар сургалтаа нээлттэй үргэлжлүүлсээр байгаа ба олон нийтэд санхүүгийн боловсролыг цахимаар түгээх, Ард Академи сувгийн тусламжтайгаар мэдлэг олгох ажлаа тасралтгүй урагшлуулсаар байна.

Эмэгтэйчүүдийн дэлхийн банкны албан ёсны гишүүнээр элсэж, хамтран ажиллахаар боллоо

Эмэгтэйчүүд, тэдний гэр бүл, хамт олонд эдийн засгийн тогтвортой байдал, хөгжин цэцэглэх боломжийг олгохын тулд шинээр хөгжиж буй орнуудын зах зээлд санхүүгийн шийдэл, бодлогын орчинг боловсруулж, хөрөнгө оруулалт хийдэг ашгийн бус байгууллага болох

Women's World Banking-ийг ивээн тэтгэж ажиллалаа. Уг хамтын ажиллагааны хүрээнд 2021 оны 10 сард Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх Захирал Г.Тэлмэн Fintech Innovation Challenge-д панелистаар оролцов.

Hackateen 2021 тэмцээний Ерөнхий спонсор-оор оролцлоо

Ард Санхүүгийн Нэгдэл хоёр дахь жилдээ Hackateen 2021 тэмцээний Ерөнхий Спонсор-оор оролцлоо. Hackateen нь Nest Education сургуулиас зохион байгуулдаг, улсын програмчлалын олимпиад бөгөөд Монгол Улс орон даяар 6-12 дугаар ангийн 600 гаруй сурагчид оролцдог билээ. Энэ удаагийн тэмцээнээр Ардын багийн хүүхдүүд амжилттай оролцож

тэргүүн болон дэд байрыг эзэллээ. Улмаар төслийн санал бэлтгэх тэмцээнд Ардын баг дэд байр, Өрсөлдөөнт Кодчилолын тэмцээнд Ардын багууд тэргүүн болон дэд байруудад шалгарсан. Шилдэг ментор-оор Ард Санхүүгийн Нэгдлийн Технологи эрхэлсэн захирал Э.Баярмагнай шалгарч энэ жилийн тэмцээнд олон амжилтыг үзүүлэв.

Хүүхэд бүрт 77 АрдКойн

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгын нэг хэсэг Хүүхэд бүрт 77 АрдКойн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. 18 нас хүртэлх хүүхэд бүрт 77 АрдКойныг олгосноороо

хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох буюу виртуал хөрөнгө, хөрөнгө оруулалтын талаар ойлголт өгөх, түүгээр дамжуулан ирээдүйг нь баталгаажуулах чухал төсөл байв.

Илгээлтийн Эзэд

Бид Монгол Улсын өнцөг булан бүрт 21 аймаг, 330 суманд санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй түгээх, зорилгоор Илгээлтийн Эзэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт 900 гаруй оюутан бүртгүүлснээс 418 нь Илгээлтийн Эзэд хөтөлбөрт амжилттай хамрагдсан. Илгээлтийн Эздийг бүс нутагт нь хуваарилахын өмнө сайтар бэлтгэн сургаж, хөтөлбөрийн бүхий

л шатанд Ардын багаас оролцогчдыг дэмжин ажилласан билээ. Хөтөлбөрт оролцогчдод 250 сая төгрөгийн шагналын санг хуваарилснаас гадна ур чадвар, авхаалж самбаагаараа шалгарсан шилдгүүдэд Ардад ажиллах боломж нээгдсэн юм. Нийт Илгээлтийн Эзэд маань хөдөө орон нутгийн 11.4 мянган иргэдэд санхүүгийн боловсролыг хүртээмжтэй түгээжээ.

Хандив	Боловсрол	Тэгш оролцоо	Ивээн тэтгэлэг
Хүүхэд бүрт 77 АрдКойн Ид шидийн орон	Hackateen Ard Students challenge	No One Left Behind. Together хөтөлбөр	Е-спорт ивээн тэтгэлэг (MESA)
Гадаадад гацсан Монголчуудад туслах Хүчтэй Хамтдаа төсөл	"Цахим алт 2" ном	Women's World Banking хамтын ажиллагаа	Токиогийн паралимпид Ардын тамирчид алтан медаль хүртэв
Эмчилгээний зардлын хандив	Илгээлтийн Эзэд	ХАСУ сан	Ардын тулаанчид "MFC USA"-д ялалт багуулав
Цар тахлын үед хамгийн эрсдэлтэй бүсэд ажилласан сувилагчдад	Байгал орчин		ICT EXPO Цахим Үндэстэн 2021
Монгол Шуудан төв салбарын шинэчлэлт	Тэрбум мод		

Хүний Нөөц

2021 онд нэгдлийн хэмжээнд 16 үндсэн ажилтантай ажилласан бөгөөд Удирдлагын багт: Гүйцэтгэх Захирал, Санхүү Эрхэлсэн Захирал, Төр Засаг, Олон Нийтийн Харилцаа Эрхэлсэн Захирал, Маркетинг Эрхэлсэн Захирал, Дотоод Аудитор, Хөрөнгө Оруулалт Эрхэлсэн Захирал, Ерөнхий Нягтлан Бодогч, Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Захирал, Эрсдэл Эрхэлсэн Захирал нар ажиллаж, оны дундаас Технологи Эрхэлсэн Захирлын албан тушаалд Эрдэнэбатын Баярмагнайг томилов. Э.Баярмагнай нь Мэдээллийн технологийн чиглэлээр 13 жил тасралтгүй ажилласан туршлагатай. Охин компаниудын удирдлагад зарим өөрчлөлт орж АрдЭкс компанийн Гүйцэтгэх Захирлаар Чулууны Ганзориг, Ард Лизинг компанийн Гүйцэтгэх захирлаар Гүррагчаагийн Сүхбаатар, Ард Секюритиз компанийн Гүйцэтгэх захирлаар Гүнрэгийн Долгорсүрэн нарыг томилов.

Тэд Ард Санхүүгийн Нэгдлийн охин компаниудад ажиллаж байсан туршлагатай, өөрсдийн мэдлэг ур чадвар, тууштай байдал болон цаашид

өсөн дэвших нөөц, бололцоогоо үнэлүүлж хариуцлагатай ажлуудыг гардан хүлээн авч ажиллахаар томилогдсон манлайлагчид юм. Харин Харилцагчийн үйлчилгээний төв буюу Ард Суппорт компанийн Гүйцэтгэх Захирлаар Цэнд-Аюушийн Солонго томилогдсон бөгөөд тэрээр Харилцаа холбоо, Харилцагчийн үйлчилгээний чиглэлээр 10 гаруй жил ажилласан туршлагатай.

Бид багаа хамгийн чадварлаг, авьяаслаг, хамгийн гол нь сэтгэлтэй залуусаар бүрдүүлэхийг эрмэлзэж ирсэн бөгөөд үйл ажиллагааны цар хүрээг тэлэн өндөр өсөлттэй байсан 2021 оны хувьд 121 ажлын байрыг шинээр бий болгожээ.

Засаглалын хувьд Ч.Ганхуяг нь Ард Секюритиз болон Ард Менежментээс гарч, Б.Золбоо, Э.Амарбаясгалан нар ажиллаж эхлэв. Энэ нь нэг хүний хамаарлыг бууруулах, залгамж халаа бэлтгэх ажлын үргэлжлэл юм.

Хөрөнгө Оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь стратегийн болон тактикийн хөрөнгө оруулалт хийдэг. Стратегийн хөрөнгө оруулалтын багцад санхүүгийн цогц үйлчилгээг нэг сувгаар үзүүлэх компаниуд ордог ба тухайн компаниудын өсөлт хөгжилд санхүү болон менежментээр тасралтгүй хөрөнгө оруулж ирсэн.

2021 онд хөрөнгө оруулалтын бүтэц түүхэн их хэмжээгээр нэмэгдэж, бизнесийн бүтцийн хувьд босоо болон хөндлөн тэлэлт хийгдлээ. Нэгдэл нь санхүү, мэдээлэл технологи, медиа, үл хөдлөх, цахим худалдаа, хөдөө аж ахуй болон сан зэрэг олон салбаруудад 256 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүнээс 226 тэрбум төгрөг нь хувьцааны 30 тэрбум төгрөг нь тогтмол орлоготой хөрөнгө оруулалт байна.

Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжлийн шинэ түвшинд гаргах, банкнаас гаднах санхүүгийн зах зээлийг бодитоор хөгжүүлэх шинэ гарц нээх зорилгоор Монголын Үнэт Цаасны Биржид хөрөнгө оруулалт хийж, бизнесийн босоо тэлэлт хийснээр Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөнд

томоохон ахиц гаргалаа. МҮЦБ нь Монгол Улсын үнэт цаасны зохицуулалттай зах зээлд биржийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 2015 оны 5 сарын 1-ний өдөр байгуулагдсан. Хөрөнгө Бүрийг Хөдөлгөнө уриан дор Монгол Улсад олон улсын стандартад нийцсэн биржийн үйлчилгээг нэвтрүүлэх замаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэлхийн түвшинд хүргэх зорилго тавин ажилладаг байгууллага юм. Ард Санхүүгийн Нэгдэл нь шууд болон МҮЦБ-ийн толгой компани болох Даац Инвестментээр дамжуулан хөрөнгө оруулалт хийснээр МҮЦБ нь ребрендинг хийж, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж буюу UBX нэрээр үйл ажиллагаа явуулах болов.

Санхүү ба технологийн салбарыг бүтээлчээр түйвээж, үйлчилгээг илүү хүртээмжтэй, хялбар байдлаар хүргэх зорилгоор Ард Санхүүгийн Нэгдэл, ГрэйпСити Монгол, МОСТ Финтек нар стратегийн түншлэлийн гэрээ 2017 онд байгуулж байв. Харин 2021 онд энэхүү санаагаа баталгаажуулж, хувьцаа солилцох байдлаар хөрөнгө оруулалтын хэлцэл хийлээ. Тус хэлцлийн үр дүнд Ард Санхүүгийн Нэгдэл нь Грэйп болон

МОСТ-ын 45 хувийг эзэмшсэн.

Грэйп нь 2000 онд байгуулагдсан бөгөөд Монголын 13 арилжааны банкны 12 нь тус компанийн програм хангамжийн бүтээгдэхүүнийг ашигладгаас 10 нь Грэйпын банкны суурь бүртгэлийн систем дээр ажиллаж байна. Грэйп нь олон улсад гарч өрсөлдөх алхмуудыг хийж эхлээд байгаа билээ. Активаар жигнэсэн үзүүлэлтээр харвал Грэйп дотоодын банкны программ хангамжийн зах зээлийн 83 хувийг эзэлж байна. Бичил санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлд зориулсан ПОЛАРИС системийг 150 орчим ББСБ, ХЗХ, бичил санхүүгийн байгууллага ашигладаг ба банкны салбарт эзэлж байгаа энэхүү онцгой байр суурь дээрээ түшиглэж МОСТ платформыг нийтийн хүртээл болгоод буй.

МОСТ нь үндэсний хэмжээний төлбөр тооцооны онлайн дэд бүтэц байгуулах зорилгоор 2008 онд байгуулагдсан. Монголбанкнаас олгодог төлбөр тооцооны сүлжээний операторын анхны бөгөөд цорын ганц лиценз эзэмшигч, Монголын анхны финтек компани бөгөөд нэг сая гаруй хэрэглэгчтэй Ард Аппын төлбөрийн үйлчилгээний дэд бүтцийг

ханган ажиллаж ирсэн юм.

Уг хамтын ажиллагааны хүрээнд Грэйп, МОСТ компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгохын өмнөх шатны хөрөнгө оруулалт буюу pre-IPO раундад бусад стратегийн хөрөнгө оруулагчдын хамтаар Ард Санхүүгийн Нэгдэл оролцох болсон бол IPO-ны андеррайтераар Ард Секюритиз ажиллахаар боллоо.

Ингэснээр **анхны нээлттэй технологийн компани Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдэж, олон нийт тус компанийн эзэн болох үүд хаалга нээгдэж байна.**

Монголын медиа салбарын анхны олон нийтийн буюу хувьцаат компани үүсгэн байгуулах зорилгоор салбарын тэргүүлэгч байгууллагуудыг нэгтгэж, E-Моние ХК-тай урвуу нэгдэл (RTO) хийснээр ТэнГэрЛиг Медиа Нэгдэл байгуулагдсан. Ард Санхүүгийн Нэгдэл нь энэхүү хэлцэлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс гадна хөрөнгө оруулалт хийснээр 40 орчим хувийг эзэмшиж байна. ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь Монгол ТВ телевиз, Промедиа Нетворк буюу ТэнГэр телевиз, Unread

Media гэсэн гурван компанийн нэгдлийн үр дүнд байгуулагдаж, нээлттэй компани болсноор олон нийт, ард иргэд хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлсэн.

Хэвлэл мэдээллийн салбарт нээлттэй компани байгуулснаар санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, эцсийн үр дүнд хараат бус, нэгдмэл редакцийн бодлоготой хэвлэл мэдээллийн хэрэгслийг бий болгох юм.

Мөн банкны бүтээлч түйвээлтийг хийх зорилгоор нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилтэд технологийн тусламжтайгаар цоо шинэ шийдэл бүрдүүлж ажиллалаа. Ард Санхүүгийн Нэгдэл нь Скопа Альянстай хамтран ажиллаж, бизнес эрхлэгч, нийлүүлэгч, эцсийн хэрэглэгч талуудыг хооронд нь нэгтгэж, тэдний харилцааг илүү хялбар, үнэ цэнтэй болгоход туслах, оролцогч талуудыг бизнесийн хөгжлийн дараагийн шатанд гарахад зориулагдсан санхүүжилтын платформыг олон нийтэд танилцуулсан. Эхний төсөл нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт нийлүүлэлтийн гинжин

хэлхээг бүтээлчээр түйвээх зорилгоор Монголын манлай хөдөө аж ахуйн хүнс үйлдвэрлэгч Гацуурт компанид санхүүжилт олгож, үйлдвэрлэгчээс эцсийн харилцагч хүртэлх санхүүгийн харилцааг хангахаар ажиллаж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд,

Ард Санхүүгийн Нэгдэл нь хүчтэй Ардын Сайн Үйлс санг үүсгэн байгуулж 100 тэрбум төгрөгтэй тэнцэх хөрөнгө оруулалт хийлээ. Харин үйл ажиллагааны ашгаар сайн үйлсийг дэмжих ажлыг эхлүүлэв.

Ард Санхүүгийн Нэгдэл нь олон нийтийг хөрөнгийн зах зээлд татан оруулах, санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Хөрөнгө оруулалтын I, II, III, IV аяныг амжилттай зохион байгууллаа. Тус аян нь хөрөнгө оруулагчид Ард Санхүүгийн Нэгдэл, түүний хамааралтай компаниудын хувьцааны багцыг худалдаж авснаар АрдКойн эзэмших эрхтэйгээрээ онцлог байв. Ирээдүйдээ хөрөнгө оруулах сонирхолтой олон мянган Монголчууд аянд нэгдэж, нийт 15,560 хөрөнгө оруулагчдаас 13 тэрбум төгрөгийг санхүүжилтийг татан төвлөрүүллээ. Мөн стратегийн хөрөнгө оруулагчдын

тоог нэмж, нийт 6 стратегийн хөрөнгө оруулагчаас 28 тэрбум төгрөгийг нэгдлийн хэмжээнд татан төвлөрүүлсэн. Жилийн хугацаанд үргэлжилсэн хөрөнгө босголтын үр дүнд:

- Ард Санхүүгийн Нэгдлийн (MSE: AARD) 19.2%
- Ард Даатгалын (MSE: AIC) 24%
- Ард Кредитын (MSE: ADB) 20.7%
- КриптоҮндэстэн Сангийн (MSE: BUN) 0.9%
- ТэнГэрЛиг Медиа Нэгдлийн (MSE: TNGR) 12%
- Үндэсний Хувьчлалын Сангийн (MSE: ХОС) 2 хувийг тус тус зарсан байна.

Харин өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахад 21.3 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн том хөрөнгө оруулагчдын нэг болох Хишигдорж овогтой Батхишиг нь өөрийн эзэмшиж буй 10 хувийг худалдсан нь гол нөлөөг үзүүлжээ.



Санхүүгийн Гүйцэтгэл

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд тайлант хугацаанд

Нийт хөрөнгө 80.4 тэрбум төгрөгөөс 331.5 тэрбум төгрөгт хүрч, **өмнөх оноос 251 тэрбум төгрөгөөр буюу 4.1 дахин өссөн байна**

Энэхүү түүхэн өсөлтөд Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны хөрөнгө оруулалтын багц буюу хөрөнгө оруулалттай компаниудын үнэлгээ 67.5 тэрбум төгрөгөөс 231.7 тэрбум төгрөг, биет бус хөрөнгө 8.9 тэрбум төгрөгөөс 59.2 тэрбум төгрөг болж өссөн нь голчлон нөлөөлсөн.

Виртуал хөрөнгийн бүртгэлд НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартын дахин үнэлгээний хандлагыг ашиглан бүртгэх аудитын зөвлөмжийн дагуу АрдКойныг биет бус хөрөнгөөр бүртгэсэн. Мөн эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх ажлын хүрээнд тогтмол орлоготой бүтээгдэхүүнд нийтдээ 10.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд хөрөнгө оруулалт хийсэн компаниуд руу санхүүжилт өгсөнтэй холбоотой авлага 1.7 тэрбум төгрөгөөс

23.2 тэрбум төгрөг болсон байна.

Ингэснээр эргэлтийн хөрөнгө 3 тэрбум төгрөгөөс 37.6 тэрбум төгрөг хүртэл, эргэлтийн бус хөрөнгө 77.3 тэрбум төгрөгөөс 293.9 тэрбум төгрөг хүртэл тус тус өсөжээ.

Нийт өр төлбөр 24.5 тэрбум төгрөгөөс 73.4 тэрбум төгрөг болж, жилийн хугацаанд 3 дахин нэмэгдсэн. Үүний 33 хувийг буюу 24.2 тэрбум төгрөг нь хойшлогдсон татварын өр буюу Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багцын өсөлтөөс үүдсэн хэрэгжээгүй ашгийн татварын өглөг юм. Ингэснээр Ард Санхүүгийн Нэгдэл нь нийтдээ 49.2 тэрбум төгрөгийн төлөгдөх өглөгтэй байгаагаас дансны өглөг 28.7 тэрбум төгрөг, богино хугацаат зээл 10.5 тэрбум төгрөг болж дийлэнх өр төлбөрийг бүрдүүлж байна. Дансны өглөг болон богино хугацаат зээл нь үйл ажиллагааны өргөжилтийг хангах зорилгоор гадна болон дотоодын байгууллагаас татсан санхүүжилт билээ. Харин бондын өглөгийг бууруулсаар 12 тэрбум төгрөгөөс 3.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй үлдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 3.3 тэрбум төгрөгийн санхүүгийн зардал гаргасан бөгөөд бидний эх үүсвэрийн дундаж өртөг тогтмол буурч 14.1 хувь болсон байна. Бид анх 2017 оны 3 сард хаалттай хүрээнд жилийн 19.2 хувийн купонтой компанийн бонд гаргаж байв.

Өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 55.8 тэрбум төгрөгөөс 258.0 тэрбум төгрөгт хүрэв. Бидний хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц 27.3 тэрбум төгрөгөөс 214.3 тэрбум төгрөг болж өссөн нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө 5 дахин өсөхөд голлон нөлөөлөв. Мөн Ард Санхүүгийн Нэгдэл нь 10.7 тэрбум төгрөгийн ашгийг хэрэгжүүлснээр хуримтлагдсан ашиг 1.4 тэрбум төгрөгөөс 12.1 тэрбум төгрөг болсон байна.

2020 онд Ард Санхүүгийн Нэгдлийн өр төлбөр нийт хөрөнгийн 30.5 хувийг эзэлж байсан бол 2021 онд энэхүү харьцаа нь 8.4 пункт нэгжээр буурч 22.1 хувь болжээ. Хөрөнгийн бүтцийн хувьд нийт хөрөнгийн 70 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт, 18 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Харин

өр төлбөрийн хувьд 59 хувь нь богино хугацаатай буюу 1 жилийн хугацаанд, 41 хувь нь урт хугацаатай буюу 1 жилээс дээш хугацаанд төлөгдөхөөр байна.

2021 онд нийт орлого 22.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 19.7 тэрбум төгрөгөөр буюу 7.4 дахин өссөн. Энэхүү өсөлтийг үүлэхэд хөрөнгө оруулалтын орлого 17.7 тэрбум төгрөг болсон нь голчлон нөлөөлөв. Мөн бид Ард Даатгал, Ард Кредит болон Монгол Шуудан компаниудаас нийтдээ 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хүлээн авсан бөгөөд энэ нь өмнөх жилийн ногдол ашгийн орлогоос 310 сая төгрөгөөр бага байлаа.

Бид үйл ажиллагаагаа өргөжүүлэн, олон нийтэд хүрч ажиллах цар хүрээгээ тэлж байгаатай холбоотой нийт зардал 3.2 дахин өсөж 23 тэрбум төгрөг болжээ. Үүнд үйл ажиллагааны зардал 2.7 тэрбум төгрөгөөс 16.3 тэрбум төгрөг болж өссөн ба 10.5 тэрбум төгрөг нь Ард Апп болон АрдКойны хөгжүүлэлттэй холбоотой зардал юм. Санхүүгийн зардлын хувьд 2.9 тэрбум төгрөгөөс 16 хувиар өсөж, 3.3 тэрбум төгрөг, хүний нөөцийн зардлын

1.6 тэрбум төгрөгөөс 31 хувиар буурч, 1.1 тэрбум төгрөг болжээ.

Зардлын харьцааг дурдвал, үйл ажиллагааны зардал нийт зардлын 70.5 хувийг эзэлснээр өмнөх жилээс 33 пунктээр нэмэгдсэн бол хүний нөөцийн зардал нийт зардлын 5 хувийг эзэлснээр 17 пунктээр, санхүүгийн зардал нийт зардлын 15 хувийг эзэлснээр 26 пунктээр тус тус буурсан байна.

Ингэснээр 2021 онд 214 сая төгрөгийн татварын дараах алдагдал бүртгэгдсэн

ч хөрөнгө оруулалтын олзоос 10.7 тэрбум төгрөгийг хэрэгжүүлж хуримтлагдсан ашиг руу шилжүүлэв.

2021 оны санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитор болох Грант Торнтоны зөвлөмжийн дагуу СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-т заасан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэх өмчид оруулсан хөрөнгө оруулалтын шаардлагыг хэрэгжүүлсэн.



Крипто төслүүд

АрдКойн

2021 оны онцлох үйл явдал

- АрдКойн эзэмшигчдийн тоо өмнөх оноос 88 хувиар өсөж, 528 мянгад хүрэв
- Дэлхийн топ-15 биржүүдийн нэг болох Bittrex Global бирж дээр бүртгэгдэв
- Бүх цаг үеийн дээд ханш болох 470 төгрөгт хүрч, арилжааны идэвх нэмэгдэн, өөрийн төрөлх бирж DAX дээр 605 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэв
- Давхардсан тоогоор 2.8 сая хүнд урамшуулал олгов
- Бирж дээрээс АрдКойныг эргэн татах хөтөлбөр хэрэгжүүлж, 180 сая ширхэг АрдКойныг амжилттай эргэн татав.

Үйл ажиллагааны тайлан

2021 онд АрдКойн эзэмшигчдийн тоо, үнэ цэнийг нэмэгдүүлэх, дотоод компаниудын борлуулалтыг дэмжих, олон улсад гарах зорилгын суурь ажлуудыг хийлээ. Дотоод компаниудын үйл ажиллагааг дэмжих зорилгын хүрээнд Ард Лайф, АрдШоп компаниудтай хамтран тэтгэврийн хуримтлалдаа орлого нэмэх, АрдШопоос худалдан авалт хийхдээ АрдКойноо 300

төгрөгөөр тооцуулах боломжийг нээсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 47'560 харилцагч тэтгэврийн хуримтлалдаа орлого хийж, 14 сая АрдКойныг татан төвлөрүүлсэн. АрдШоптой хамтран ажилласнаар 17'949 харилцагч 7.9 сая АрдКойноор хөнгөлөлт эдэлж, худалдан авалтаа амжилттай хийсэн нь Ковидын үед цахим худалдааг дэмжихэд тус нэмэр боллоо.

АрдКойн олон улсад гарах зорилгын хүрээнд дэлхийн топ биржүүдийн нэг Bittrex Global, төвлөрсөн бус бирж болох Uniswap, дэлхийн томоохон төвлөрсөн бус хэтэвч олох Metamask, Trust wallet дээр бүртгэгдэж, криптовалют сонирхогчид олон улсын харилцагч АрдКойныг худалдан авах, хадгалах боломжийг нээсэн. Олон улсад гарах ажлын хүрээнд хамгийн том эхлүүлсэн ажил нь iDAX олон улсын бирж бөгөөд АрдКойноор шимтгэл төлөх, АрдКойн барьцаалж зээл авах, АрдКойноо хадгалан өгөөж хүртэх гэх мэт олон шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болов.

АрдКойноо урт хугацаанд хадгалж байгаа харилцагчдыг урамшуулах зорилгоор HODL хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд 20'667 хүн 420 сая АрдКойныг Ард Апп дээрх өөрсдийн АвДартаа хадгалж байна. АрдКойны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хадгалж

буй АрдКойны тоо хэмжээнээс хамаарч Ардын холбоотой бүх компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авах боломж нээгдсэн. Мөн АрдКойныг СКОПА төслийн үндсэн урамшууллын оноо болгож, бизнес бүр АрдКойныг урамшуулалдаа ашиглан, өөрсдийн борлуулалтыг дэмжих боломжийг нээсэн.

2020 оны 12 сард АрдКойны төрөлх бирж болох DAX амжилттай үйл ажиллагаагаа эхлүүлснээр 2021 онд ARDX/BTC, ARDX/ARDT, ARDX/ETH, ARDX/USDT-тэй хослолууд хамгийн өндөр арилжааны идэвхтэй байж нийт 1.8 тэрбум АрдКойны арилжаа хийгдсэн байна. Харин АрдКойны төгрөгтэй (ARDX/MNT) хослол дээр 3.5 тэрбум АрдКойн буюу 605 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна. 2021 онд АрдКойны арилжааны хувьд 175-300 төгрөгийн ханшийн хэлбэлзэлд нийт арилжааны 65 хувь нь хийгдсэн.

Тоон үзүүлэлт

Шинэ харилцагч нарт олгосон урамшуулал

Реферал	Харилцагчийн тоо	Олгосон АрдКойн (сая)
Харилцагчийн баталгаажуулалт	348,921	36.0
И-мэйл баталгаажуулалт	117,489	8.8
Найзаа урьсны урамшуулал	220,259	21.9
Фэйсбүүк баталгаажуулалт	128,852	10.1
АрдКидс	6,327	3.2
Бусад	67,208	3.9
Нийт	889,056	83.9

Бүтээгдэхүүн үйлчилгээнд олгосон урамшуулал

Компани	Харилцагчийн тоо	Олгосон АрдКойн (сая)
Ard Credit	1,487,307	36.7
Ard Insurance	19,401	65.2
Ard Securities	242,953	16.2
Ard Life	153,644	27.9
Ard Assets	829	7.3
Ard Shop	17,949	1.3
Ard Holdings	63,208	64.7
Нийт	1,985,291	219.3

Эрсдэлийн удирдлага

Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллах Ард Санхүүгийн Нэгдлийн үндсэн зарчмын хүрээнд, бид үлгэр жишээ засаглалын бүтцийг нэвтрүүлж, олон улсын стандартад нийцүүлэн Ард Санхүүгийн Нэгдлийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-өөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлого, тогтолцоог хэрэгжүүлж ажилладаг.

ТУЗ нь эрсдэлийн удирдлагын гол чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэдэг бол нэгдлийн удирдлага болон ажилчид үйл ажиллагааны бүх түвшинд хамгаалалтын гурван шугамын дагуу хэрэгжүүлэх үүргийг ухамсарлан гүйцэтгэж 2021 оныг үдлээ.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хөл хорио, эдийн засгийн саармагжилт, бизнесийн зогсонги байдал зэрэг нь бидний үйл ажиллагаанд томоохон шалгуур болсны зэрэгцээ эдгээрээс үүдсэн цахим шилжилт нь алдаж боломгүй

боломжийг нээж өгсөн юм. Шинээр үүсэж буй нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, боломж тохирсон бизнесийн болон эрсдэлийн удирдлагыг шуурхай хэрэгжүүлж, нөхцөл байдалд уян хатан хандаж ажиллав.

Халдвар хамгааллын дэглэмийг бүрэн сахих үүднээс ажиллагсдадаа гэрээс ажиллах боломжийг бүрэн нээж өгснөөс гадна хувьцаа эзэмшигч, харилцагчдын асуудлыг ч цахимаар болон утсаар шийдвэрлэх процессуудыг тодорхойлон ажилласан. Гэсэн хэдий ч салбар болон харилцагчийн үйлчилгээний ачааллыг дийлэхгүй байх нөхцөл байдал үүсэж байв. Тухай цаг алдалгүйгээр системийн чадавхаа сайжруулах, харилцагчийн үйлчилгээний төвийн хүчин чадлыг тэлэх арга хэмжээг авч ажилласан. Мөн салбарын ачааллыг бууруулахын тулд салбар дээр ирэлгүйгээр, цахимаар асуудлаа шийдвэрлүүлж буй харилцагчдад урамшуулал олгосон.

Цар тахал нь цахим шилжилтийн хурдасгуур болж, бидний суурийг нь хэдийн бэлдсэн байсан Ард Апп болон виртуал хөрөнгийн бирж болох DAX нь иргэдийн төлбөр тооцоо, санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг бүрэн шийдвэрлэж байсан боловч нөгөөтээгүүр харилцагчдын дутуу мэдээлэл, систем болон хяналтын сул талыг ашиглан залилан, луйврын шинжтэй үйлдлүүд гарч байв. Бид кибер эрсдэлээс хамгаалан систем, хяналтын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж, анхааруулах болон шийдвэрлэх боломжтой харилцагчдын асуудлыг тухай шийдвэрлэж, шийдэх боломжгүйг нь хууль, цагдаагийн байгууллагад шилжүүлэн ажиллалаа. Залилангийн шинжтэй үйлдлийг таслан зогсооход

Ардын зүгээс үйл ажиллагаа, хяналт, системээ чангатгахаас гадна харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэн өөрсдийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах нь чухал байдгийг жилийн тайландаа цохон тэмдэглэе.

2021 онд хөрөнгийн болон криптовалютын зах зээл савалгаатай байсан учир зах зээлийн ханш, хүү, хөрөнгө оруулалтын эрсдэлийг, эдийн засаг тогтворгүй, тодорхой бус байсан учир зээлийн эрсдэл болон компаниудын хөрвөх чадварын эрсдэлийг, нийтэд нь санхүүгийн системийн эрсдэлийг тогтмол хянаж, зохистой түвшинд хадгалахад онцгой анхааран ажилласан.

Хууль, хянан нийцүүлэлт

Ард Санхүүгийн Нэгдэл нь Хууль эрх зүйн болон бизнесийн орчинд шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллах зарчимтай. Үүнийхээ хүрээнд компанийн бизнесийн үйл ажиллагааны холбогдох хууль, журмыг дагаж мөрдөхийн зэрэгцээ эрх бүхий байгууллагаас боловсруулан гаргаж буй хууль тогтоомж, дүрэм журамд санал, бодлоо илэрхийлж,

идэвхтэй байр сууриас хандан ажиллахыг эрмэлздэг. Бид хуулийн хянан нийцлийг хангаж, комплаенсын эрсдэлийг удирдах ажлын хүрээнд зохицуулагч байгууллагуудтай нягт хамтран ажилласаар ирсэн.

2021 оны онцлох хууль тогтоомжоос дурдвал:

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль

2021 оны 12 сарын 17-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль-ийн эцсийн хэлэлцүүлгийг хийж УИХ-ын гишүүдийн олонхи дэмжин баталсан билээ. Ард Санхүүгийн Нэгдэл нь Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Монголын Финтек, Блокчэйны Зөвлөлөөр дамжуулан тус хуулийн төслийн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, саналаа хүргүүлэх байдлаар идэвхийлэн оролцсон.

Уг хууль батлагдсанаар Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчин эх, ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, хяналт шалгалтын тогтолцоо эх, мэдээллэх үүрэгтэй этгээдийг тодорхойлох, салбарын эрсдэлийг үнэлэх, стандарт шаардлагад нийцсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй болох зэрэг ач холбогдолтой юм.

Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2021 оны 7 сарын 2-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Уг хуулийн төслийг 2018 оны 3 сарын 28-нд УИХ-д өргөн барьсан бөгөөд өмнөх хууль батлагдсанаас даруй 22 жилийн дараа ийнхүү батлагдаж байгаа чухал хууль юм. Шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор бид 2021 онд Хөдөлмөрийн дотоод журам, заавар, гэрээ зэрэг хөдөлмөрийн харилцааг зохицуулсан дотоод эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх, бэлтгэл ажлаа эхлүүлсэн.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиас гадна Цахим хөгжлийн багц хуулиуд болох Нийтийн мэдээллийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төслүүдийг 2021 онд УИХ-ын чуулганаар мөн баталсан. Эдгээр багц хуулиуд 2022 оны 5 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Энэхүү багц хуулиудыг судалж, компанийн үйл ажиллагааг нийцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Хөрөнгө оруулалтын багц

Санхүү






— Ард Санхүүгийн Нэгдэл



— Холбоотой этгээд

 Нээлттэй компани



Нийгмийн хариуцлага





Медиа



Платформ



IT



Ард Даатгал (MSE: AIC)

2021 оны онцлох үйл явдал

- Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексэд тасралтгүй дөрвөн жил багтав
- Хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оноос 5 дахин нэмэгдэж 10,151 хүрэв
- Нийт 6 жил, нээлттэй хувьцаат компани болсноос хойш тасралтгүй 3 дах жилдээ хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилав
- 2021 онд нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашиг буюу нийт 1 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилав
- Осолгүй, манлай жолооч хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жил осол, аваар гаргаагүй хариуцлагатай даатгуулагчиддаа АрдКойны урамшуулал олгов
- Монгол Улсын уул уурхай, барилга, сэргээгдэх эрчим хүчний салбарын даатгалын томоохон тоглогч болов
- Монгол Улсад анх удаа Хүнд өвчний даатгал-ын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэв
- Гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монголчуудыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлж буй Хоум Моргейж Корпорэйшн ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, орон сууцны зээлийн даатгалын үйлчилгээ үзүүлж эхлэв
- Мэдээлэл, бүртгэлийн үндсэн систем, харилцагчийн үйлчилгээний систем (call center), харилцагчийн менежментийн систем (CRM)-ийг уялдуулан, шаардлагатай тохиолдолд цахимаар ажиллах бүрэн боломжтой болсон ба мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллав
- Цахим даатгалын шийдлийг хэвшил болгож, утсаар, цахимаар, Ард Аппаар даатгалын үйлчилгээ үзүүлэв
- Цахим даатгалын үйлчилгээ үзүүлэхээр ДАН системтэй хамтран ажиллаж байна.

Үйл ажиллагааны тайлан

2021 онд Ард Даатгал ХК нь Улаанбаатар хот болон орон нутгийн 24 салбар нэгж, төлөөлөгчийн газар, системийн нөлөө бүхий 5 арилжааны банк, олон улсын болон дотоодын 70 гаруй брокер, мэргэжлийн оролцогч зуучлагч, банк бус санхүүгийн байгууллага, 158 даатгалын төлөөлөгчөөр дамжуулан

Улс орон даяар **50 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна.**

Улс орны баялаг бүтээж буй 2 мянга гаруй байгууллагатай 15 мянга гаруй гэрээ байгуулан, нийтдээ 200 мянга гаруй иргэнд даатгалын үйлчилгээ үзүүллээ. Компанийн хувьд харилцагч бүр үнэ цэнтэй. Өнгөрсөн жил Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас ТОП-100 аж ахуйн нэгжийг эрэмбэлсэн. Тэдгээр аж ахуйн нэгж байгууллагын 50


хувиас дээш хэсэгт шууд хэлбэрээр, 80 хувиас дээш хэсэгт нь дам хэлбэрээр үйлчилгээ үзүүлжээ. Мөн үүнээс гадна 200 гаруй Төрийн байгууллагуудад даатгалын үйлчилгээ давхар үзүүлсэн байна.

2021 онд Ард Даатгал компанийн нийт хөрөнгө өмнөх оноос 21 хувиар өсөж 34.8 тэрбум төгрөгт, өөрийн хөрөнгө 38 хувиар өсөж 18.4 тэрбум төгрөгт хүрсэн бол тайлант үеийн хугацаанд 16.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэн, 5.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 5,700 даатгуулагчид олголоо. Даатгалын компанийн үндсэн орлогоос гадна ашгийг бүрдүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг хөрөнгө оруулалтын багц 25.1 тэрбум төгрөгт, хөрөнгө оруулалтын орлого 9.3 тэрбум төгрөгт хүрснээр 7.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

Хувьцааны арилжаа

Мөн тайлангийн жилд 9.4 сая ширхэг хувьцаа эргэлтэд орж, нийт 11.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, Монголын Хөрөнгийн Бирж дээрх хамгийн хөрвөх чадвар сайтай хувьцаануудын нэг байсаар байна. Хувьцааны үнийн хувьд

тайлангийн жилд 705-1,800 төгрөгийн хооронд хэлбэлзэж, жилийн эцэст 1,319 төгрөгийн үнэтэй хаагдсанаар өмнөх оноос 65 хувиар өсөж, компанийн зах зээлийн үнэлгээ 33.0 тэрбум төгрөгт хүрсэн.



Нийт хөрөнгө болон
Өөрийн хөрөнгө
(Сая төгрөг)



Санхүүгийн гол үзүүлэлт



Ард Кредит (MSE: ADB)

2021 оны онцлох үйл явдал

- Хөрөнгө оруулагчдад зориулж Fast Cash White хөнгөлөлттэй зээлийг нэвтрүүлэв
- 2020 оны цэвэр ашгаас 1 тэрбум төгрөгийг 10,323 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилав
- Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексэд тасралтгүй 3 дахь жилдээ багтаж, Хувьцаат компанийн I ангилалд дэвшин оров
- Монголын Банкны Холбооны гишүүн байгууллага болов
- Япон улсын Крауд Кредит сантай хамтын ажиллагааг сайжруулан, эх үүсвэрийн өртгийг бууруулж, хэмжээг нэмэгдүүлэв
- Итгэлцэл, тэтгэврийн хуримтлал барьцаалсан зээл, виртуал хөрөнгө барьцаалсан зээлийг Ард Аппаар дамжуулан олгож эхлэв
- Улаанбаатар хотын төв цэг болох Төв Шууданд салбараа нээв
- Frontier Fintech Summit 2021 арга хэмжээнд ерөнхий спонсороор оролцов.

Үйл ажиллагааны тайлан

2021 онд Ард Кредит ББСБ ХК-ийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 2.5 дахин өсөж, 73.4 тэрбум төгрөгт, зээлийн багц 1.8 дахин нэмэгдэж 36.6 тэрбум төгрөгт хүрснээр 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекст тасралтгүй 3 дахь жилдээ багтан, МХБ-ийн I ангилалд дэвшин орж, нэгж хувьцааны үнэ түүхэн дээд ханш болох 351.12 төгрөгт хүрсэн.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Ард Даатгал ХК, Монгол Шуудан ХК-тай хамтран, 21 аймагт

Fast Cash зээлийг олгодог болсон ба виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээг салбартаа анх удаа нэвтрүүлж, итгэлцэл барьцаалсан зээл, тэтгэврийн хуримтлал барьцаалсан зээл, хадгаламж барьцаалсан зээл зэрэг бүтээгдэхүүнүүдийг Ард Аппд үе шаттай нэвтрүүлж ажилласан.


Цар тахлын онцгой цаг үед нийт ажилтнууд болон харилцагч нарынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг ханган ажиллах, төлбөрийн чадвар муудсан харилцагч нараа дэмжих, бизнесийн зээлийн хүүг бууруулах, харилцагчаа урамшуулах зэрэг үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж ажиллав.



Хувьцааны арилжаа


ADB	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Өдрийн дундаж арилжаа	Нийт арилжааны дүн	Арилжигдсан тоо ширхэг
2021/01/01 2021/12/31	₮79	₮351	₮77	₮220	2.8x	₮79,215,159	₮19,724,574,688	106,750,675

	2020	2021		2020	2021
Хувьцаа эзэмшигчдийн тоо	2,139	13,702	Хаалтын үнэ	₮82	₮220
Нийт хувьцааны тоо	280 сая	280 сая	P/E-Үнэ/Ашиг	18.1x	15.7x
Зах зээлийн үнэлгээ	₮22,988 сая	₮61,580 сая	P/B-Үнэ/Дансны үнэ	2.0x	2.7x



Хаалтын ханш	₮219.93		2020	2021
Дээд болон доод үнэ	₮77-₮351	EPS (TTM)	₮4.5	₮15.0
Нийт эргэлтэд байгаа хувьцааны тоо	280,000,000	P/E (TTM)	18.1x	14.7x
Нийт арилжааны дүн	₮19.7 тэрбум	P/B	2.0x	2.3x
Зах зээлийн үнэлгээ	₮61.6 тэрбум			
Арилжаалагдсан хувьцааны тоо	106.8 сая ширхэг			

Зээлийн гол үзүүлэлт



Санхүүгийн гол үзүүлэлт

Сая төгрөг



Ардын Тэтгэврийн Данс

2021 оны онцлох үйл явдал

- Ард Лайф ХХК оноосон нэрээ Ардын Тэтгэврийн Данс ХХК болгон өөрчлөв
- Харилцагчдын тоо 100,000-д хүрэв
- 22 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж хуваарилав
- Нийт хуримтлалын дүнгийн 1 хувьтай тэнцэх АрдКойноор харилцагчдаа урамшуулав
- Шинэ харилцагчдадаа нийт хуримтлалын дүнгийн 2 хувьтай тэнцэх АрдКойны урамшуулал олгов
- Тэтгэврийн хуримтлал барьцаалсан зээлийг Ард Кредит ББСБ-тай хамтран нэвтрүүлэв.



Үйл ажиллагааны тайлан

2021 онд Ардын Тэтгэврийн Данс ХХК-ийн нийт хөрөнгө 216 хувиар өсөж, 62.1 тэрбум төгрөгт, харилцагчдын тоо 863 хувиар өсөж 100,600, хөрөнгө оруулалтын үнэлгээ 729 хувиар өсөж 22.4 тэрбум, нийт тэтгэврийн хуримтлал 308 хувиар өсөж 13.8 тэрбумд хүрсэн амжилттай жил өнгөрлөө.

Хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх нөхцөлтэй хуримтлалын данс нээсэн харилцагч нартаа 2021 оны хөрөнгө оруулалтын 22 хувийн өгөөжийг хуваарилав.

Тэтгэврийн дансны орлогыг АрдКойноор авч эхэлсэн ба зах зээлийн ханшаас 10 хувь, 20 хувь, 30 хувиар өндөр ханшаар тооцож ирэв.

Санхүүгийн гол үзүүлэлт

Тэтгэврийн хуримтлал (сая төгрөг)	2019		1,699
	2020		3,393
	2021		13,849
Нийт хөрөнгө (сая төгрөг)	2019		18,269
	2020		19,681
	2021		62,261
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн нөөц (сая төгрөг)	2019		1,092
	2020		2,706
	2021		21,796
Нийт дэлгэрэнгүй ашиг (сая төгрөг)	2019		989
	2020		601
	2021		21,742

Ард Актив

2021 оны онцлох үйл явдал

ТОП 3	НИЙТ ХӨРӨНГӨ	ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ	ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ
Нийт хөрөнгийн тэргүүлэх 3 том хоршооны нэг болов	Хоршооны нийт хөрөнгийн хэмжээ 30 тэрбум төгрөгт хүрэв	20 сая төгрөг хүртэлх хадгаламжийг Ард Даатгал ХК-аар даатгуулав	Хоршооны гишүүд 30 хүртэлх сая төгрөгийн хадгаламж барьцаалсан зээлийг Ард Аппаар авах боломжтой болов

- Хоршооны гишүүдийн тоо 2.5 дахин өсөж 2,678-д хүрэв.

Үйл ажиллагааны тайлан

Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо нь анх 2004 онд Траско ХЗХ нэртэйгээр үүсгэн байгуулагдсан ба 2013 онд Ард Актив ХЗХ болгон нэрээ өөрчилсөн.

2021 онд Ард Актив ХЗХ-ны нийт хөрөнгө өмнөх оноос 4 дахин нэмэгдэж 30 тэрбум төгрөгт, хувь нийлүүлсэн хөрөнгө

8 дахин нэмэгдэж 7.4 тэрбум төгрөгт, нийт хүүгийн орлого 3 дахин нэмэгдэж 2.5 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 27 дахин нэмэгдэж 406 сая төгрөгт хүрсэн.

2021 онд сард дунджаар 2.1 тэрбум төгрөгийн хадгаламж татсанаар нийт хадгаламжийн хэмжээ 21 тэрбум төгрөгт

хүрсэн. Харин сард дунджаар 3.4 тэрбум төгрөгийн зээл олгож, нийт цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 4 дахин нэмэгдэж 21 тэрбум төгрөгт хүрсэн. Сайн зээлийн түүхтэй, барьцаа хөрөнгө болон орлогын хүрэлцээ сайн гишүүддээ

бага хүүтэй зээл олгон ажилласнаар чанаргүй зээлийн багцыг 0.1 хувьд хүргэсэн. Энэ нь салбарын дундаж үзүүлэлт болох 3.5 хувиас 35 дахин бага үзүүлэлт юм.

Санхүүгийн гол үзүүлэлт

Нийт хөрөнгө (сая төгрөг)	2019		4,142
	2020		6,869
	2021		30,229
Чанаргүй зээлийн хувь	2019		1.05%
	2020		0.54%
	2021		0.12%
Цэвэр ашиг (сая төгрөг)	2019		37
	2020		15
	2021		406
Гишүүдийн тоо	2019		732
	2020		1,062
	2021		2,678

Ард Менежмент

2021 оны онцлох үйл явдал

- Монголын хамгийн анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын санг амжилттай удирдаж, сангийн цэвэр хөрөнгийг 91.2 хувиар өсгөж, 4.9 тэрбум төгрөгөөс 9.3 тэрбум төгрөгт хүргэв
- Монголын анхны хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажлын эхлэл тавигдан судалгаа шинжилгээ, дүрэм журмыг боловсруулан, бичиг баримтыг бүрдүүлж дуусгав
- Монголын хөрөнгийн зах зээл дээрх анхны нээлттэй медиа нэгдлийг 5 сарын дотор үүсгэн байгуулсан ба өдгөө тус групп 120 тэрбум төгрөгийн үнэлгээтэй компани болов
- Амьдралын даатгалын үйлчилгээ үзүүлэх нээлттэй хувьцаат компанийг үүсгэн байгуулах ажлыг эхлүүлэв
- Криптовалютад хөрөнгө оруулалт хийх зорилготой Монголын анхны нээлттэй хувьцаат компанийг өлгийдөн авсан ба уг компанийн зах зээлийн үнэлгээ өдгөө 18 тэрбум төгрөгт хүрэв.

Үйл ажиллагааны тайлан

Ард Менежмент нь Монголын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан (цаашид ХОС гэх)-г 2020 онд үүсэн байгуулсан бөгөөд 2021 онд ХОС-ийн хөрөнгийг амжилттай удирдаж, бидэнд итгэсэн хөрөнгө оруулагчдын итгэлийг бататгаж,

хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийн хөгжлийн эхлэлийг тавилаа. Үүний тод жишээг бол ХОС-д хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртэх сонирхолтой хөрөнгө оруулагчдын тоо 2021 онд 6,325-д хүрч, өмнөх оноос 2.6 дахин өссөнөөс харж болно. 2021 онд Ард Менежмент нь

ХОС-ийн хөрөнгийг дотоодын төдийгүй гадны хөрөнгийн зах зээлд байршуулж, хөрөнгө оруулалт хийснээр 91.2 хувийн өгөөжтэй ажиллажээ. Энэ нь бидний зорьж байсан дундаж хөрөнгө оруулалтын өгөөж болох 17.6 хувийн өгөөжөөс 73.6 нэгжээр өндөр үзүүлэлт юм. Ингэснээр 2021 оны эхэнд ХОС-ийн цэвэр хөрөнгийн үнэлгээ 4.9 тэрбум төгрөг байсан бол оны төгсгөлд 9.3 тэрбум төгрөг, зах зээлийн үнэлгээ 9.9 тэрбум төгрөгт хүрсэн. Ард Менежмент нь ХОС-ийн хөрөнгийг удирдаж багц бүрдүүлэхээс гадна, 2021 оны 4 сарын 26-ны өдөр нэгж эрх эзэмшигчдийн анхдугаар хурлыг цахим хэлбэрээр 2,245 нэгж эрх эзэмшигчтэйгээр амжилттай зохион байгуулсан. Сангийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг сар бүр гаргаж сангийн нэгж эрх эзэмшигч, холбогдох байгууллагуудад тогтмол мэдээллэж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллав.

Бид өөрсдийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд Хөрөнгө Оруулагч Үндэстэн хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг боловсруулж 2021 оны 4 сарын 9-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороонд илгээлээ. Үүсгэн байгуулах зөвшөөрөл гарснаар Монголын анхны хамтын нээлттэй ХОС мэндэлнэ.

Мөн хөрөнгө оруулагчдын хөрөнгийг үр

ашигтай өсгөх зорилгын хүрээнд өсөлт үзүүлэх потенциалтай, өрсөлдөхүйц хөрөнгө оруулалтын хэрэгслүүд олох шаардлага зайлшгүй үүссэн. Уг ажлын хүрээнд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон компанид хөрөнгө оруулалт хийснээр үйл ажиллагааг нь сэргээхийн тулд тулж ажиллав. Үүний үр дүнд гайхалтай хөрөнгө оруулалтуудын өгөөжийг хүртсэн жил байлаа. Тухайлбал Булган Ундрага ХК-ийн нэгж хувьцааны үнэ оны эхэнд 874.9 төгрөг байсан бол оны төгсгөлд 164,900 төгрөг болж огцом өсөж, зах зээл дээр нийлүүлэлт байхгүй ховор хувьцаануудын нэг боллоо. Мөн 2021 оны 2 сарын 9-ний өдөр Е-Моние ХК-ийн 90.4 хувийг худалдан авч, компанийн нэрийг Тэнгэрлиг Медиа Нэгдэл ХК болгон, энтертэйнмент медиа чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар өөрчлөн байгуулах, нэмж хувьцаа гаргах ажлуудыг асар богино хугацаанд амжилттай хийж гүйцэтгэснээр бидний анхны хөрөнгө оруулалт 13 дахин өсөж, 1.3 тэрбум төгрөг боллоо.

Харин өнгөрсөн оны эцэст бид Өндөрхаан ХК-ийн үйл ажиллагааг Амьдралын Даатгал болгон өөрчлөхөөр баримт бичгүүдийг боловсруулж, судалгаа хийн ажиллаж байна.

Санхүүгийн үзүүлэлт

2021 онд Ард Менежмент компани нь 812 сая төгрөгийн орлоготой, 690 сая төгрөгийн зардалтай, 89 сая төгрөгийн цэвэр ашигтай, 5.1 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй ашигтай ажилласан.

Тайлант онд Ард Менежмент нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажилласнаас гадна, компани нэгтгэх, өөрчлөн байгуулж үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлсэн байна.

Сая төгрөг	2019	2020	2021	CAGR	YoY
Нийт хөрөнгийн дүн	378	2,021	7,889	2.75x	3.9x
Урт хугацаат хөрөнгө оруулалт	342	369	1,923	78%	5.2x
Эздийн өмч	121	1,597	6,999	3.87x	4.4x
Нийт дэлгэрэнгүй орлого	31	575	5,403	5.59x	9.4x

Эх сурвалж: Ард Менежмент ҮЦК ХХК-ийн урьдчилсан санхүүгийн тайлан

Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)


2021 оны онцлох үйл явдал

Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:XOC) нь 2020 оны 10 сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 1 жил 2 сарын хугацаанд сангийн цэвэр хөрөнгийн дүн 5 тэрбумаас 9.3 тэрбум төгрөгт хүрч онцгой өсөлтийг үзүүлсэн. 2021 оны эцсийн байдлаар нэгж эрхэд


ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 186.51 төгрөгт хүрч өмнөх оноос 91.2 хувь, зах зээлийн үнэ 199.01 төгрөгт хүрч өмнөх оноос 83.2 хувиар тус тус өссөн байна. ХОС-ын зорилтот өгөөжийн хэмжээ жилийн 17.6 хувь бөгөөд 2021 онд 73.6 хувиар давуулан биелүүлсэн.

МХБ арилжааны эргэлт
6.85 тэрбум төгрөг


Санхүүгийн зах зээлийн үнэлгээ
(тэрбум төгрөг)




Нэгж эрх эзэмшигчдийн тоо



Зах зээлийн үнэлгээ



Өртөгөөр



- Дотоод хувьцаа
- Гадаад хувьцаа
- Бонд
- Хадгаламж
- Бэлэн мөнгө
- Бусад актив

Крипто Үндэстэн (MSE: BUN)

2021 оны онцлох үйл явдал

- Компанийн нэрийг Крипто Үндэстэн ХК болгон өөрчлөв
- Компанийн зарласан хувьцааны тоо ширхгийг 1,000,000-д хүргэв.
- Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөв
- Компанийн шинэчилсэн дүрмийн найруулгыг батлав
- Компанийн хаягийг Булган аймгаас Улаанбаатар хот руу шилжүүлэв.

Үйл ажиллагааны тайлан

2020 оны 12 сарын 17-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр Ард Бит ХХК нь Булган Ундарга ХК-ийн 99.9 хувийг худалдаж авсан. Ингэснээр компанийн

үйл ажиллагааг сэргээж, блокчэйн технологи болон криптовалютын салбарт үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм.

MSE: BUN	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Нийт арилжааны дүн ₮	Арилжигдсан тоо ширхэг
2021	874.9	224,300	874.9	164,900	18,747%	2,581,729,811	41,974

Ард Секюритиз

2021 оны онцлох үйл явдал

- Ард Секюритиз ҮЦК Монголын Хөрөнгийн Бирж дээрх хоёрдогч зах зээлийн арилжааны дүнгээр салбараа тэргүүлэв
- Цар тахлын үед цахим үйлчилгээгээ тэлж, 4 үйлчилгээг шинээр нэвтрүүлэн, нийт 15 бүтээгдэхүүн үйлчилгээг Ард Аппаар хүргэв
- 2021 онд харилцагчдын тоо 62 хувиар өсөж, шинэ харилцагчийн тоогоор салбартаа тэргүүлэв
- Степ Голд компанийн андеррайтаар ажиллаж, Степ Голд компани нь нээлттэй компани болох зөвшөөрлөө авав
- Хаалттай бондын андеррайтераар ажиллаж, нийт 44.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай босгов
- Санхүү, дэд бүтэц, мэдээлэл технологийн компаниудад хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлэн, 8 компанид санхүү, хуулийн магадлан шинжилгээ хийж хөрөнгийн зах зээлд хөл тавих эхлэлийг нь бүрдүүлж өгөв
- Компани үйл ажиллагааны цар хүрээгээ тэлсэнтэй холбоотой боловсон хүчний тоо 2 дахин нэмэгдэв.

Үйл ажиллагааны тайлан

2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа болон сангийн нэгж эрхийн 724 тэрбум төгрөгийн арилжаа хийгджээ. Үүнээс 232 тэрбум буюу нийт арилжааны 32 хувийг Ард Секюритиз ҮЦК дангаараа бүрдүүлэв.

Андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцагч компаниудад санхүүгийн зөвлөх үйлчилгээг үзүүлснээс гадна 4 хаалттай бондын материал дээр ажиллан, нийт 44.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг босголоо.

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Степ Голд компанийн андеррайтаар ажиллаж, Монголын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлийн зөвшөөрлийг авав.

Нээлттэй бондын арилжаа, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж, хамтран эзэмшигч, мөнгө хүсэх зэрэг үйлчилгээг Ард Аппад шинээр нэвтрүүлэн, харилцагчдаа нийт 15 үйлчилгээг цахимаар үзүүлж байна.


Харилцагчдын арилжааны идэвх өмнөх оноос 2 дахин нэмэгдэж, давхардсан тоогоор 40 мянган харилцагч Ард Аппаар үнэт цаасны арилжаанд оролцов.

Санхүүгийн гол үзүүлэлт


2021 онд YoY

Сая төгрөгөөр

Үйл ажиллагааны орлого

2.4 тэрбум төгрөг **3x**

Нийт зардал

2.1 тэрбум төгрөг **2x**

Цэвэр ашиг

1.6 тэрбум төгрөг **+1.8 тэрбум**

Нийт хөрөнгө

20.3 тэрбум төгрөг **4x**

АрдШоп

2021 оны онцлох үйл явдал

- Өмнөх онтой харьцуулахад бүртгэлтэй хэрэглэгчдийн тоог 3, борлуулалтын эргэлтийг 10 дахин өсгөсөн амжилт гаргав
- Монгол Шуудан ХК-тай хамтран хүргэлтийн Төвийн үйл ажиллагааг эхлүүлснээр хүргэлтийн үйл ажиллагааны хурд, үр ашиг нэмэгдэв
- АрдКойнтой хэрэглэгчдэд зориулсан AfterPay худалдан авалтын зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв
- Хүүхдэд ээлтэй бүтээгдэхүүнийг АрдКидс аппаар борлуулж эхлэв.

Үйл ажиллагааны тайлан

АрдШоп цахим худалдааны платформ нь технологийн шинэ шийдлүүдийг нэвтрүүлж, тус платформоор дамжуулан бараа бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд борлуулдаг бизнес эрхлэгчдэд онлайн бизнесээ өргөжүүлэх боломжийг олгодог. Ингэснээр хэрэглэгчдэд таашаагдсан бүтээгдэхүүний сонголт өдөр ирэх тутам нэмэгдэж, АрдШопоор үйлчлүүлэх хэрэглэгчдийн тоо тасралтгүй өссөөр байна. 2021 онд АрдШопод бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо өмнөх оноос 3 дахин нэмэгдэж 800,000-д хүрсэн бол борлуулалтын эргэлт 10 дахин өссөн.

Хэрэглэгчдэд хэрэгцээт бүтээгдэхүүнийг түргэн шуурхай хүргэх, хүргэлтийн үйл ажиллагааг оновчтой болгох зорилгоор АрдШоп өөрийн Хүргэлтийн Төвийн үйл ажиллагааг 2021 оны IV улирлаас эхлэн амжилттай явуулж байна.

АрдКойн лоялти хөтөлбөрийн хүрээнд АрдШоп 2021 онд онцгой урамшуулалт аянуудыг амжилттай зохион байгуулснаар Ковидын цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хүндрэлийг улс орноороо даван туулахад бодит

хувь нэмрээ оруулав. Урамшуулалт аянаар дамжуулан ард иргэд хэрэгцээт бүтээгдэхүүнээ хямдралтай үнээр худалдан авах боломж сэн бол АрдШопын харилцагч, бизнес эрхлэгчдэд энэ нь борлуулалтаа нэмэгдүүлэх бодит дэмжлэг болжээ. Мөн АрдКойнтой хэрэглэгчдэд зориулсан AfterPay худалдан авалтын зээлийн үйлчилгээг нэвтрүүлснээр 500,000-аас 5,000,000 төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг урьдчилгаагүй цахим зээлээр авах боломжийг бүрдүүлсэн.


АрдШоп онлайн дэлгүүр нь АрдКидс хүүхдийн санхүүгийн анхны аппд хүүхдэд ээлтэй бүтээгдэхүүнээ оруулж, бяцхан хэрэглэгчдэдээ үйлчилж эхэлсэн байна. Цахим худалдааны үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ АрдШоп нь Монголын анхны NFT

дуудлага худалдаа, Ардын Альфа урамшуулал, хөгжөөнт тоглоом зэрэг Ард Аппын хамгийн сонирхолтой үйлчилгээнүүдийг технологийн шийдлээр ханган ажиллалаа.


Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хэрэглэгчдийн цахим хэрэглээ эрс нэмэгдэж, худалдан авалтын зан төлөв, эргэлт буцалтгүй өөрчлөгдсөн билээ. Онлайн дэлгүүр, хүргэлтийн үйлчилгээгүйгээр худалдааны бизнесийг төсөөлөх боломжгүй болсон энэ цагт АрдШоп нь бизнес эрхлэгчдэд цахим худалдааны оновчтой шийдэл, Монгол Шуудангийн орон даяарх хүргэлт, АрдКойн лоялти хөтөлбөрийг санал болгодог шилдэг түнш юм.

Онцлох үзүүлэлт

Бүртгэлтэй хэрэглэгчийн тоо



Захиалгын тоо




Ард Лизинг

2021 оны онцлох үйл явдал

- Нийт 3.4 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэв
- 2021 онд Гадас хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэв
- Өсдөг машин хөтөлбөрийг олон нийтэд танилцуулж, унаж яваа машинаараа хөрөнгө оруулалт хийх боломжийг харилцагчдад олгосон. Уг бүтээгдэхүүн нь санхүүгийн зах зээлд шинэлэг, орчин үеийн бүтээгдэхүүн байсан төдийгүй нийт 1.7 тэрбум төгрөгийн лизингийн үйлчилгээг олон нийтэд санал болгов
- Өсдөг Машин хөтөлбөрийн хүрээнд харилцагчдадаа оновчтой, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын багцыг санал болгохын тулд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2.1 хувийг эзэмшсэн ба түүний охин компаниудад 690 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв
- Харилцагч, үйлчлүүлэгчдэдээ үйл ажиллагаагаа хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэхийн тулд Монгол Улсын 20 аймаг, 3 дүүрэгт нийт 23 салбараа нээв
- 15.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэв.

Санхүүгийн гол үзүүлэлт

Хөрөнгө (Сая төгрөг)	2019		2,183.24
	2020		2,569.62
	2021		26,267.40
Өр төлбөр (Сая төгрөг)	2019		2,183.77
	2020		1,453.04
	2021		21,573.82
Эздийн өмч (Сая төгрөг)	2019		(0.53)
	2020		325.25
	2021		4,693.58
Цэвэр ашиг (Сая төгрөг)	2019		(0.65)
	2020		13.61
	2021		448.33
Нийт орлого (Сая төгрөг)	2019		62.02
	2020		213.70
	2021		448.33

АрдЭкс

2021 оны онцлох үйл явдал

- Digital Assets Exchange (DAX)- ын вэб хувилбарыг нэвтрүүлэв
- ETH болон USDT хослолуудыг нэмэв
- ERC-20 сүлжээний зарлагыг нэмэв
- ARDT буюу Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг токенжуулан арилжаалж эхлэв
- Crypto Cash буюу виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэв
- IHC болон URG койны IEO-г амжилттай зохион байгуулав
- MONT буюу Монголын анхны төгрөгтэй аргамжсан стэйблкойн төслийг амжилттай хэрэгжүүлэв
- DAX - Виртуал Хөрөнгийн Биржид хамгийн идэвхтэй арилжаа хийсэн харилцагчдаа урамшуулав
- АрдЭкс ХХК ашгаас 3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний MONT-ыг АрдКойн эзэмшигчдэдээ хуваарилав
- АрдМааний буюу Монголын анхны DAO төслийг эхлүүлэв
- DAXT төслийг амжилттай эхлүүлэв
- iDAX биржийг амжилттай нэвтрүүлэв.


Үйл ажиллагааны тайлан

АрдЭкс ХХК нь 2021 оны 3 сараас вэб хувилбарт шилжсэн. 2021 онд төгрөгийн арилжааны шимтгэл 7.5 тэрбум төгрөгт хүрсэн бол хүснэгтэд харуулж


байгаагаар 1.2 ихнайд төгрөгтэй тэнцэх АрдКойн, 556 сая төгрөгтэй тэнцэх Их койн арилжаалагдсан байна.

	Арилжааны дүн	Нэг талт арилжааны дүн	Арилжааны дүн	Арилжааны дүн	Жилийн өсөлт
	(хэмжээ)	(хэмжээ)	(төгрөг)	(АрдКойн)	3.8x
ARDT	19,721,209	9,860,605	70,031,205,782	627,339,545	5.3x
ARDX	6,927,861,019	3,463,930,510	1,213,941,813,553		4.2x
MONT	14,997,696,374	7,498,848,187	14,878,425,929		3.5x
URG	16,818,857,767	8,409,428,884	11,641,283,477		3.8x
ARDM	102,498,263,994	51,249,131,997		135,960,776	5.3x
IHC	137,310,643,190	68,655,321,595	556,558,141,535		4.2x
USDT	5,768,021	2,884,011	12,103,772,711	23,993,110	3.5x
BTC	1,088	544	55,177,801,872	708,845,256	4.2x
ETH	11,494	5,747	35,589,817,900	340,069,514	3.5x
ADMC	878,193,222	439,096,611	865,198,971		3.8x
Нийт			1,970,787,461,731	1,836,208,202	

Харилцагчдын тоо




Шинээр бүртгүүлсэн харилцагчид



Нийт харилцагчид
180K

Койн эзэмшигчдийн тоо



ТэнГэрЛиг Медиа Нэгдэл (MSE: TNGR)

2021 оны онцлох үйл явдал

- Е-Моние компанитай урвуу нэгдэл хийж, ТэнГэрЛиг Медиа Нэгдэл байгуулагдан, МХБ-д TNGR тикерээр бүртгэгдэв
- Монгол Телевиз ХХК, Анрид ХХК, Ори Студиос ХХК болон Про Медиа Нетворк ХХК-д хөрөнгө оруулалт хийв
- СЗХ-ны зөвшөөрлийн дагуу 5,941,457 хувьцаа нэмж гаргаснаар нийт гаргасан хувьцааны тоо 6,000,000 болов
- Ори студийн барилгын ажил эхэлж, студийн шавыг тавив
- VTV нэрээ ТэнГэр ТВ болгон туршилтын эфирээ цацаж эхлэв
- TNGR.media албан ёсны вэбсайттай болов.



TenGerLeague
Media Group

TNGR

Үйл ажиллагааны тайлан

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны бүрэн хараат бус, олон нийтийн эзэмшил бүхий нээлттэй хувьцаат компани болох зорилготойгоор Е-Моние ХК-тай урвуу нэгдэл хийн, нээлттэй компани болсон. ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр ажиллаж байгаа бөгөөд МонголТВ ХХК (20%), ТэнГэрТВ буюу Про Медиа Нетворк ХХК (80%), Анрид ХХК (66%), Ори Студиос ХХК (20%) компаниудад хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаагаа тэлсээр байна.

Цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа эхлүүлсэн хэдий ч маш амжилттай бөгөөд хурдтайгаар өнгө төрхөө тодорхойлж, ребрэндинг хийлээ. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оноос 434 хувиар өсөж, 556 боллоо.

Монголын медиа салбарын хамгийн анхны олон нийтийн, ил тод, хараат бус байдлыг хангасан, нэгдмэл редакцийн бодлоготой, нээлттэй хувьцаат медиа нэгдэл байгуулагдсанаар олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөж хүртэх боломж лээ.

Нэгж хувьцааны үнэ түүхэн дээд ханш болох 36,700 төгрөгт хүрсэн нь оны эхний ханш болох 2,179 төгрөгөөс 16.8 дахин өссөн үзүүлэлт юм. 2021 онд компанийн зах зээлийн үнэлгээ 818 хувиар өсөж, 120 тэрбум болов.

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь контент үйлдвэрлэгч бүхий л оролцогч талуудыг нэг дор нэгтгэсэн контент хаб, кино студи байгуулах ORI Studios төслийг хөгжүүлэн, бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлээд буй. Про Медиа Нетворк буюу хуучнаар VTV-ийг ТэнГэр ТВ болгон ребрэндинг хийж шинэчлэн, цоо шинэ телевизийн студи босгосон бөгөөд 2021 оны 12 сарын 31-нд анхны тусгай эфирээ цацсан. Уг шинэ телевиз нь үйл

ажиллагаагаа жигдрүүлэн, 2022 оны II улиралд цоо шинэ өнгө төрх, контентын бодлогоо танилцуулах юм. Дээрх хоёр компанид нийт 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Харин Unread Media компанийн хувьд ажил хэрэгч хүмүүс, залуу мэргэжилтнүүдэд зориулсан контентуудынхаа тоог нэмэгдүүлэх, хэлбэрийг төрөлжүүлэх шинэ төслүүдийг эхлүүлсэн. Мөн ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь Монгол Дифай ХХК-д хөрөнгө оруулж, 10 хувийг эзэмших болсон.

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл нь уламжлалт болон дижитал медиа, OTT, технологийн инновациудыг нэгтгэж, контентын боломжит бүх төрлөөр, төхөөрөмжид үл хязгаарлагдан хүргэхээр зорьдог бөгөөд цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, зах зээлийг тэлэн, үр нөлөөг ихэсгэж, түүгээрээ дамжуулан нийгмийг эерэг өөрчлөлтөд хөтлөх зорилготой юм. 2022 онд уг зорилтуудын хүрээнд хэвлэл мэдээлэл, контентын зах зээлд тэсрэлт хийх төслүүдийг бэлэн болгохоор ажиллаж байна.

MSE: TNGR	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Өдрийн дундаж арилжаа ₮	Нийт арилжааны дүн ₮	Арилжигдсан тоо ширхэг
2021/01/01-2021/12/31	2,179	39,000	2,179	20,000	9.2x	135,663,527.12	7,732,821,046.00	1,211,829

	2020	2021		2020	2021
Хувьцаа эзэмшигчдийн тоо	128	556	Хаалтын үнэ	-	₮20,000
Нийт хувьцааны тоо	0.05 сая	6 сая	P/E-Үнэ/Ашиг	-	289.9
Зах зээлийн үнэлгээ	-	₮120 тэрбум	P/B-Үнэ/Дансны үнэ	-	4,088.9

Онцлох үзүүлэлт



Монгол Шуудан (MSE: MNP)

2021 оны онцлох үйл явдал

- Цахим шилжилтийн хүрээнд компанийн вэбсайтыг шинэчлэж, гар утасны апп шинээр хөгжүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэв
- Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтаар Төв шуудангийн үйлчилгээний салбарт их засварын ажлыг хийж өнгө төрхийг шинэчлэв
- Улаанбаатар хотод 4 салбар шинээр болон байршил сайжруулан байгуулав (25, 36, 53, Хүннү Молл)
- 7 салбарын өнгө төрхийг сэргээж жишиг салбарын засвар хийлээ (22, 23, 24, 37, Булган, Ховд, Говьсүмбэр) аймаг салбаруудын засварыг хийж өнгө төрхийг шинэчлэн үйлчлүүлэгч болон ажилчдад ая тухтай орчныг бүрдүүлэн ажиллав
- Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, операторын тоог нэмэгдүүлэн ажилласнаар үйлчлүүлж буй иргэдийн ачааллыг бууруулах, дуудлагад цаг алдахгүй хариулах санал гомдлыг барагдуулах тал дээр анхаарч ажиллав
- Сумдын үйл ажиллагаа дэмжих сүлжээ ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд Юнител компанитай хамтран ажилласнаар 2020 оны борлуулалттай харьцуулахад 10 дахин нэмэгдүүлэн борлуулалтыг өсгөлөө. Цаашдаа хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор шинэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллахаар болов
- Гараас Гарт хүргэлтийн үйлчилгээнд зориулж probox автомашинаар хүчин чадлаа нэмэгдүүллээ. Ингэснээр цар тахлын үед хэрэглэгчдэд илүү ойртон эрсдэлийг бууруулах хүртээмжтэй үйлчилгээг олон нийтэд хүргэхийг зорин ажиллав
- Ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмийн үед үйлчлүүлэгчийн илгээмжийг А-Б

цэгт саадгүй хүргэх, хүргэлтийн үйлчилгээний ачааллыг бууруулах зорилгоор хувь хүмүүс болон такси үйлчилгээний компаниудтай хамтран

- E-Mongolia-аар захиалсан 33,964 ширхэг гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг хаягт эзэнд хүргэх ажлыг зохион байгуулан хамтран ажиллав
- Монгол Улсад орчин цагийн харилцаа холбоо, шуудан мэдээллийн технологийн салбар үүсч хөгжсөний 100-н жилийн ойн хүрээнд 21 сэдвийн шинэ маркийг бүтээж гүйлгээнд оруулан түүхийг мөнхөлж чадсан онцлог жил болов
- Хөшигийн хөндийд олон улсын стандартад нийцсэн, шуудангийн аюулгүй байдлыг бүрэн хангасан УХШЯБТ-ийг барьж ашиглалтанд оруулах ажил хийгдэв
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд СХД-ийн 24-р хорооны нутаг дэвсгэрт мод тарих ажлыг хийж гүйцэтгэв
- Дэлхийн Шуудангийн Холбооны (ДШХ) чанарын сангийн санхүүжилтийн хүрээнд шинэ Тоёота HIACE маркийн автомашин хүлээн авлаа. Дэлхийн Шуудангийн Холбооны техник

хамтын ажиллагааны төсөл, чанарын дундын сангийн санхүүжилтээр компьютер, принтер, жин, бусад тоног төхөөрөмжийг худалдан авав

- Цар тахлаас шалтгаалж төгсөгчдийн диплом хүргэлтийн үйлчилгээг Монгол Шуудангаар дамжуулан эх орны өнцөг булан бүрт суугаа эздийнх нь гарт хүргэх ажлыг зохион байгуулан ажилласнаар 2020 онд нийт 9 сургуулийн 3,875 дипломыг хүргэн ажилласан бол 2021 онд 7,474 ширхэг дипломыг хүргэж, өмнөх онтой харьцуулахад 1,8 дахин нэмэгдэн эздийнх нь гарт саадгүй хүргэх ажлыг зохион байгуулав
- 2020 оны Монгол улсын шилдэг татвар төлөгч 20 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав
- НҮБ-ын мэргэжлийн төрөлжсөн байгууллага болох Дэлхийн Шуудангийн Холбоо гишүүн орнуудын шуудангийн хөгжлийн индексийг жил бүр шинэчлэн тогтоодог. Энэ жилийн мэдээгээр


Монгол Шуудан цар тахлын хүнд нөхцөлд +24.43 хувийн өсөлтийг үзүүлж 2021 онд (2020 оны үзүүлэлтээр) **нийт дэлхийн 168 орноос 57 дугаар байр эзлэв**

Бидний ойрын ирээдүй

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилго тавин ажилладаг Ард Санхүүгийн Нэгдэл нь Монгол орны өнцөг булан бүрийг хамарсан Скопа Альянс ХХК-ийн нэвтрүүлж буй GOOD платформыг санхүүжүүлэхээр болсон. Уг төсөлд жижиг, дунд, бизнес эрхэлж буй хувь хүн, аж ахуй нэгж бүр оролцох боломжтой бөгөөд үйлдвэрлэгч, мерчант, эцсийн хэрэглэгчийн бүхий л харилцааг GOOD платформоор дамжуулан шийдэж байгаагаараа онцлог юм. Үйлдвэрлэгчид энэхүү платформд нэгдсэнээр бараа бүтээгдэхүүнийхээ борлуулалтын орлогыг шууд хүлээн авч төлбөр, тооцооны асуудлаа шийдэж, борлуулалтын орлогоо нэмэгдүүлэхээс

гадна үйл ажиллагааны зардлаа үлэмж хэмжээгээр бууруулах томоохон давуу талыг эдэлнэ. Харин худалдаа эрхлэгчдийн хувьд өртөг багатай санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай авснаар барааны захиалгаа цаг алдалгүй хийж, бизнесийн орлогоо нэмэгдүүлэх зэрэг олон шинэлэг боломжуудыг хүртэх юм.

2020 оны 12 сард Кripto Үндэстэн Сан үйл ажиллагаа өргөжүүлэх, илүү олон хөрөнгө оруулагчдад хүрэх зорилгоор нээлттэй хувьцаат компани болохоор шийдвэрлэж, Булган-Ундрага компанитай урвуу нэгдэл хийсэн. Булган-Ундрага компани 2021 оны



хувьцаа эзэмшигчдийн хурлаараа компанийн нэрийг өөрчлөх тухайд 100 хувь санал нэгдсэнийг Санхүүгийн Зохицуулах Хороо хүлээн авч, зөвшөөрснөөр цаашид Кripto Үндэстэн ХК нэрээр үйл ажиллагаагаа явуулах боллоо. Кripto Үндэстэн ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь криптод суурилсан хөрөнгө оруулалт буюу криптовалютын зах зээлийн судалгаа, шинжилгээний үндсэн дээр багцаа бүрдүүлж, хөрөнгөө өсгөх замаар хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Криптовалютад хөрөнгө оруулалт хийдэг Хөрөнгө оруулалтын сан (ETF), нээлттэй хувьцаат компани дэлхийн хэмжээнд маш ховор байдаг бол

Кripto Үндэстэн ХК нь Монголчуудад криптовалютад хөрөнгө оруулалт хийх, өөрийн хөрөнгийг мэргэжлийн багаар удирдуулах боломжийг нээж өгчээ.

Төвлөрсөн бус санхүүжилтийн (DeFi) технологийг бүрэн эзэмших ажилд анхаарал төвлөрүүлэн ажиллах болно. Мөн давтагдашгүй бүтээлийг блокчэйн дээр бүртгэдэг NFT технологийг Монголд анхлан нэвтрүүлэхээр судалж, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

Хоёр жилийн хугацаанд завсардсан Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулганыг 2022 онд зохион байгуулахаар зорин ажиллаж байна.

**МОНГОЛЫН
ХАМГИЙН ТОМ
БИЗНЕСИЙН
ПЛАТФОРМ**

Хараат бус аудитын тайлан

Хураангуй санхүүгийн тайлангийн
талаарх

Хараат бус аудиторын дүгнэлт

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа
эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2021 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь хураангуй санхүүгийн тайлан гэх) 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул Ард санхүүгийн нэгдэл ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2022 оны 3 сарын 31-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн. Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлуудад СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-т өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, Виртуал хөрөнгийн бүртгэл, СТОУС 16 Түрээс-тэй холбоотой ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөлт, СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан-д заагдсан хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн статусыг хангах тухай зэрэг асуудлуудыг авч үзсэн бөгөөд бид энэ асуудлуудаар дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага:

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад

нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

.....

Б.ОСОРГАРАВ

УДИРДАХ ПАРТНЕР

Монгол улс, Улаанбаатар хот

2022 оны 3 сарын 31

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2021 оны	2020 оны
	12 сарын 31-ний үлдэгдэл	12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	330,722	100,958
Дансны болон бусад авлага	23,076,380	1,685,343
Бусад санхүүгийн хөрөнгө	10,369,946	18,737
Бараа материал	107,959	2,112
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,708,456	1,243,564
Эргэлтийн хөрөнгийн дүн	37,593,463	3,050,714
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	645,221	466,025
Биет бус хөрөнгө	59,160,237	8,941,367
Ашиглах эрхтэй хөрөнгө	2,349,551	440,433
Урт хугацаат хөрөнгө оруулалт	231,730,778	67,481,313
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	293,885,787	77,329,138
Нийт хөрөнгө	331,479,250	80,379,852

Мянган төгрөгөөр	2021 оны	2020 оны
	12 сарын 31-ний үлдэгдэл	12 сарын 31-ний үлдэгдэл
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	28,703,917	4,552,360
Богино хугацаат зээл	10,516,124	1,147,287
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	3,685,489	11,958,106
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	979,547	349,718
Богино хугацаат өр төлбөрийн дүн	43,885,077	18,007,471
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр	24,188,557	3,405,208
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	1,473,974	379,093
Урт хугацаат зээл	6,633,373	408,752
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	1,583,000	2,347,232
Урт хугацаат өр төлбөрийн дүн	33,878,904	6,540,285
Өр төлбөрийн нийт дүн	73,430,648	24,547,756
Эздийн өмч		
Өмч-хувьцаат	28,614,263	28,590,335
Халаасны хувьцаа	-	(1,414,706)
Нэмж төлөгдсөн капитал	2,927,696	
Дахин үнэлгээний нөөц	214,347,421	27,284,096
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	12,145,423	1,358,572
Эздийн өмчийн дүн	258,048,602	55,832,096
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	331,479,250	80,379,852

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	2,030,180	688,461
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	17,708,213	303,915
Ногдол ашгийн орлого	1,004,162	1,311,736
Хөрөнгө оруулалтын багцын хүүгийн орлого	1,316,383	29,984
Нийт хөрөнгө оруулалтын орлого	7,707,431	2,334,096
Борлуулалт, маркетингийн зардал	(1,095,852)	(271,381)
Ерөнхий ба удирдлагын зардал	(16,266,063)	(3,183,791)
Санхүүгийн зардал	(3,346,137)	(2,876,353)
Бусад зардал	(2,349,625)	(785,887)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(361)	(170,140)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(26,955)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	16,266,063	3,183,791
Орлогын татварын зардал (өгөөж)	27,437	2,041
Тайлант үеийн цэвэр алдагдал	(214,350)	(4,034,675)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгийн үнэлгээний олз	187,063,325	3,178,618
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгөөс хэрэгжсэн олз	11,805,694	1,056,403
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн	198,869,019	4,235,021
Нийт дэлгэрэнгүй ашиг	198,654,669	200,346
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал	(0.01)	(0.15)

Өмчийн өөрчлөлтийн
тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	24,105,478	13,799	5,287,424	56,582,330
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(4,034,675)	(4,034,675)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	4,235,021	-	-	4,235,021
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(950,580)	(950,580)
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(1,056,403)	-	1,056,403	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	27,284,096	13,799	1,358,572	55,832,096
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(214,350)	(214,350)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	198,869,019	-	-	198,869,019
Өмчид гарсан өөрчлөлт	23,928	1,414,706	2,927,696	-	-	(23,928)	4,342,402
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(11,805,694)	-	11,025,129	(780,565)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,614,263	-	2,927,696	214,347,421	13,799	12,145,423	258,048,602

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	2,782,715	417,427
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,782,715	-
Бусад мөнгөн орлого	-	417,427
Мөнгөн зарлагын дүн	8,302,909	4,928,032
Ажиллагчдад төлсөн	1,487,785	435,619
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	271,633	73,927
Бараа материал худалдан авахад төлсөн	117,682	10,421
Ашиглалтын зардалд төлсөн	52,037	622,131
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	135,533	15,773
Хүүний төлбөрт төлсөн	2,730,145	1,825,104
Татварын байгууллагад төлсөн	1,001,667	119,558
Даатгалын төлбөрт төлсөн	26,755	10,903
Бусад мөнгөн зарлага	2,479,672	1,814,596
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,520,194)	(4,510,605)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	51,176,390	3,272,094
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	10,800,405	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	20,850,000	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	17,665,239	3,197,168
Хүлээн авсан хүүний орлого	957,000	900
Хүлээн авсан ногдол ашиг	903,746	74,026

Мянган төгрөгөөр	2021 он	2020 он
Мөнгөн зарлагын дүн	49,492,446	1,407,956
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	601,044	3,823
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	100,000	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	13,587,474	1,143,667
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	35,203,928	260,466
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,683,944	1,864,138
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	20,768,079	9,922,914
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,768,079	3,749,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	6,173,914
Мөнгөн зарлагын дүн	16,702,065	7,218,725
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	16,415,124	2,918,723
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	137,863	224,543
Хувьцаа буцаан худалдаж авхад төлсөн	-	3,768,800
Төлсөн ногдол ашиг	149,078	306,659
Бусад мөнгөн зарлага	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,066,014	2,704,189
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	229,764	57,722
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,958	43,236
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	330,722	100,958